

UCS 0802A:2020

НОГООН БАЙГУУЛАМЖ



Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй
ажиллагааны удирдамж

НОГООН БАЙГУУЛАМЖ

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй
ажиллагааны удирдамж



ГАРЧИГ

1	Зорилго.....	4
2	Хэрэглэх хүрээ	4
3	Норматив эшлэл	4
4	Нэр томъёоны тайлбар.....	4
5	Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах шаардлага.....	5
	5.1 Шинээр ажилтан бэлтгэх үеийн сургалт	5
	5.2 Үйлдвэрлэл, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх ажилтанд сургалтаар олгох зааварчилгаа.....	5
	5.3 Мэргэжил дээшлүүлэх үеийн сургалт.....	6
6	Цэцэрлэгчийн ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага.....	7
	6.1 Эргономик шаардлага	7
	6.2 Ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага.....	8
	6.3 Тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага.....	8
	6.4 Өвлийн хувцасны загвар.....	9
	6.5 Зуны хувцасны загвар.....	10
	6.6 Ажлын тусгай хувцасны материалд тавигдах шаардлага.....	11
	6.7 Ажлын хувцасны хэмжээ.....	11
	6.8 Будаг, шохойн ажлын үед өмсөх хувцас.....	12
	6.9 Ашиглалтын хугацаа.....	13
	6.10 Цэвэрлэгээ.....	14
	6.11 Тэмдэглэгээ.....	14
	6.12 Ажлын гутлын стандарт.....	14
	6.13 Гарын хамгаалалт бээлий.....	15
7	Анхны тусламжийн хайрцаг, түүний иж бүрдлийн шаардлага.....	16
	7.1 Анхны тусламж.....	16
	7.2 Анхны тусламжийн тухай ерөнхий ойлголт.....	18
	7.3 Амьсгалын үйл ажиллагаа алдагдсан үед үзүүлэх анхны тусламж.....	20
	7.4 Зүрхний үйл ажиллагаа гэнэт зогсох үед үзүүлэх анхны тусламж.....	21
	7.5 Ясны хугарал.....	22
8	Цэцэрлэгчийн ажлын байранд тогтмол хийгддэг ажил.....	24
	8.1 Цэцэрлэгчний ажлын байранд нийтлэг хийгддэг ажлын аюулгүй ажиллагаа.....	24
	8.2 Цэцэг тарих үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа.....	29

8.3	Зүлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажлын зааварчилгаа.....	30
8.4	Ногоон байгууламжийн арчилгааны ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажлын зааварчилгаа.....	30
8.5	Гар багажтай ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгаа.....	33
8.6	Машин тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгаа.....	36
9	Цэцэрлэгчинд учирч болзошгүй осол, гэмтэл.....	37
9.1	Осголт.....	37
9.2	Халууны цохилт.....	38
9.3	Түлэгдэлт.....	39
9.4	Хамрын цус алдалт.....	41
10	Цэцэрлэгчийн ажлын байрны ахуйн шаардлага.....	43
10.1	Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа.....	43
10.2	Цэцэрлэгчийн ажлын орчин	43
10.3	Хоолны газар.....	45
11	Цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл.....	45
11.1	Цэцэрлэгчийн үүрэг.....	45
11.2	Цэцэрлэгчний ажиллах орчин, мэргэжлийн онцлог.....	46
11.3	Цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл.....	47
12	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тэмдэг.....	50
13	Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны удирдамжийн шалгуур үзүүлэлт.....	51
	Ашигласан материал.....	52

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 6.1 Ажлын тусгай хувцас.....	9
Хүснэгт 6.2 Хувцасны хэмжээний хүснэгт.....	12
Хүснэгт 6.3 Эрэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа.....	12
Хүснэгт 6.4 Эмэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа.....	12
Хүснэгт 11.1 Хаврын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл.....	47
Хүснэгт 11.2 Зуны улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл.....	48
Хүснэгт 11.3 Намрын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл.....	49
Хүснэгт 11.4 Өвлийн улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл.....	49
Хүснэгт 13.1 Цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шалгуур үзүүлэлт.....	51

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 6.1 Өвлийн хувцасны загвар.....	10
Зураг 6.2 Цэцэрлэгчийн зуны хувцасны хийц.....	11
Зураг 6.3 Будаг шохойн хувцас.....	13
Зураг 6.4 Цэцэрлэгжүүлэлтийн хөдөлмөр хамгааллын гутал.....	15
Зураг 7.1 Анхны тусламжийн хайрцаг.....	18
Зураг 7.2 Анхны тусламжийн хэрэгсэл.....	18
Зураг 7.3 Артерийн судасны цус алдалтын үед чангалуур тавьж боох.....	19
Зураг 7.4 Үе мөчний яс хугараагүй боловч шархнаас цус алдаж байх үеийн боолт хийх арга.....	20
Зураг 7.5 Залгиурт тээглэсэн гадны биетийг авах арга.....	21
Зураг 7.6 Амьсгалын дээд замд ус орсон үед авах арга хэмжээ.....	21
Зураг 7.7 Амнаас аманд зохиомол амьсгал хийх арга.....	21
Зураг 7.8 Зүрхний ажиллагаа гэнэт зогсох үед үзүүлэх анхны тусламж.....	22
Зураг 7.9 Дээд мөчний гэмтлийн үед гарыг сойх.....	23
Зураг 7.10 Дээд мөчний гэмтэл.....	23
Зураг 7.11 Шилбэний ясны хугарал.....	23
Зураг 7.12 Дунд чөмгийн хугарал.....	23
Зураг 7.13 Нурууны гэмтлийн үед үзүүлэх тусламж.....	24
Зураг 8.1 Цэцэрлэгчийн сууж ажил гүйцэтгэхэд ашиглах сандал.....	29
Зураг 8.2 Хортон шавжтай харьцах үед болгоомжлох.....	31
Зураг 8.3 Мод сөөгийг хэлбэржүүлэх танах.....	32
Зураг 8.4 Цэвэрлэгээний огтлол.....	33

Зураг 8.5 Гар багаж ашиглах	33
Зураг 8.6 Багажийг ирлэх, ир солих.....	34
Зураг 8.7 Ирмэг, хурц иртэй багаж.....	34
Зураг 8.8 Багажийг үүрч, түрж явах.....	35
Зураг 8.9 Багажийн ирийн эргэлт.....	35
Зураг 8.10 Ажлын талбайн норм баримталж бусдыг гэмтээхгүй байх.....	36
Зураг 9.1 Биеийн хөлдсөн хэсгийг усанд дүрэх.....	37
Зураг 9.2 Бүх биеийг дулаацуулах.....	37
Зураг 9.3 Хүйтний улиралд биеийн захын хэсгүүд болох чих, хамар, хацар, эрүү, гар, хөлийн үзүүрийн хөлдөлтүү.....	38
Зураг 9.4 Халууны цохилтод орох.....	39
Зураг 9.5 Цахилгааны эрчим хүчний эх үүсвэрээс өвчтөнөөс холдуулах.....	40
Зураг 9.6 Түлэгдэлтийн зэргээс хамаарах тусламжийн арга хэмжээнүүд....	41
Зураг 9.7 Хамрын цус алдалтанд зөв арга хэмжээг авах.....	42

НОГООН БАЙГУУЛАМЖ

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны Удирдамж

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичиг нь ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуй нэгжүүдийн, ажил гүйцэтгэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлэн, осол гэмтэлгүй ажиллах, хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг дээшлүүлэхэд оршино.

2. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн ажил гүйцэтгэгч, иргэн, энэ чиглэлээр хяналт тавих эрх бүхий байгууллагуудад хамаарна.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

1. MNS 4931-2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага.
2. MNS 5621-2006 Толгой хамгаалах хэрэгсэл дуулга.
3. MNS 5622-2006 Гарын хамгаалалт (бээлий).
4. MNS 5623-2006 Хөлийн хамгаалалт ажлын тусгай гутал. MNS 13688-2000 Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага.

4. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэгчид- гэж ажлын үе шатанд оролцож ажиллах инженер, мэргэжилтэн, техникч, цэцэрлэгчин, гэрээт ажилчид;

Техникч- гэж тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тохиргоо хийх, хяналт тавих, техникээр ажил гүйцэтгэгч;

Цэцэрлэгчин- гэж цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн мод бут сөөг, цэцэрлэгжүүлсэн талбайг арчлан хамгаалах, тарьж ургуулах ажлыг гүйцэтгэгч;

Ажлын тусгай хувцас- гэж гаднын нэг болон хэд хэдэн хүчин зүйл, тааламжгүй сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилгоор тусгайлан хийсэн хувцас;

Ашиглалтын хугацаа- гэж хувцсыг хийсэн материалын анхны ? хийсэн шинж чанарт хадгалалт, ашиглалтын явцаас хамаарч тодорхой хугацааны дараа гарах нэг буюу хэд хэдэн өөрчлөлт;

Ажлын тусгай хувцасны ангилал- гэж хөдөлмөрийн нөхцөлөөс хамаарч ажилтнуудыг ажлын хувцсаар хангагдах ажил мэргэжил, албан тушаалын ангилал, нэрс;

Синтетик холио- гэж даавуун дахь синтетик буюу хиймэл ширхэгтийн орцын хувь, хэмжээ;

Байгалийн гаралтай ширхэгт- гэж байгаль дээр байх амьтны болон ургамлын гаралтай ширхэгт, ноос, ноолуур, хөвөн, олс гэх мэт;

Өнгө материал- гэж хувцасны хамгийн гадар талын даавуу;

Дотрын материал- гэж гадуур хувцсыг өмсөх, тайлахад хялбар байлгах, дотор талд өмссөн хувцастай барьцалдахгүй байлгах зориулалт бүхий материал;

Атлас нэхээс- гэж гөлгөр гадаргуу үүсгэн нэхсэн даавуу (дотрын материал);

Сарж нэхээс- гэж диагональ хээ үүсгэн нэхсэн даавуу;

Физик химийн шинж чанар- гэж хими, физикийн үйлчлэлийн нөлөөгөөр өөрчлөгдөх шинж чанар;

Физик механик- гэж гаднын механик үйлчлэлийн нөлөөгөөр өөрчлөгдөх шинж чанар;

Дотрын дотроос салдаг дотор- гэж тухайн хувцасны дотор талд давхар үе болгон хийсэн дулаалга;

Дотроос салдаг дулаалга- гэж тухайн хувцасны дотор талд давхар үе болгон хийсэн дулаалга;

5. ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ШААРДЛАГА

5.1 ШИНЭЭР АЖИЛТАН БЭЛТГЭХ ҮЕИЙН СУРГАЛТ

5.1.1 Шинээр ажилтан бэлтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг энэ асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

5.1.2 Шинээр ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын холбогдох шаардлагыг заавал оруулна.

5.1.3 Шинээр ажилтан бэлтгэх үеийн аюулгүй ажиллагааны сургалтыг өндөр мэргэжилтэй ажилтан, мэргэжлийн багш удирдаж хийлгэнэ.

5.1.4 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар олсон мэдлэгийг тогтоосон журмын дагуу шалгах ба тэнцээгүй хүмүүсийг давтан сургалтад хамруулж дахин шалгалт авна.

5.2. ҮЙЛДВЭРЛЭЛ, НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТАНД СУРГАЛТААР ОЛГОХ ЗААВАРЧИЛГАА

Үйлдвэрлэл ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг байгууллага дахь ХАБЭА-н ажилтан, дарга сургалтыг зааварчилгаа өгөх хэлбэрээр зохион байгуулна. Зааварчилгаа нь дараах 3 хэлбэртэй байна. Үүнд:

Урьдчилсан зааварчилгаа - Байгууллагын өвөрмөц онцлог, дотоод дүрэм, техникийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал,

хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин (МШӨ), хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно. Урьдчилсан зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тохижуулсан зориулалтын танхимд хариуцсан мэргэжилтэн, инженер, техникийн ажилтан өгнө. Урьдчилсан зааварчилгаа өгөх хугацаа нь аюулгүй ажиллагааны журамд заасан хэмжээгээр тогтоогдох бөгөөд 2 цагаас багагүй байна;

Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа - Ажлын байр өөрчлөгдөх үед, ажилд шинээр орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирсэн хүмүүст өгнө. Ажлын бүх үе шатуудад хийгдэх, ашиглагдах, багаж тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, ашиглалт, осолдогчдод үзүүлэх анхны тусламж үзүүлэх зэрэг зааварчилгаануудыг өгнө. Зааварчилгааг байгууллагын ХАБЭА-н мэргэжилтэн болон тухайн ажлын байрыг хариуцсан инженер, удирдлага батлагдсан журмаар өгнө;

Давтан зааварчилгаа - Давтан зааварчилгааг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө. Энэ зааварчилгаа нь гурван хэлбэртэй байна. Үүнд:

- Ээлжит (улиралд нэгээс доошгүй удаа өгнө);
- Ээлжит бус (шинэ технологи нэвтрэх, хөдөлмөрийн нөхцөлд өөрчлөгдөх, байгууллагын журамд өөрчлөлт орсон, ажилтан удаан хугацаагаар ажлаас хөндийрөөд эргэж ажилласан тохиолдолд зааварчилгаа өгнө);
- Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа (Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө бичгээр өгч
- бүртгэлийн журнал хөтөлнө);

Зааварчилгааны хөтөлбөр, хичээлийн сэдвийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан боловсруулж, ҮЭ-ийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тухайн байгууллагын ерөнхий менежер (инженер), орлогч дарга батална.

5.3. МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮЕИЙН СУРГАЛТ

5.3.1 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны мэргэжил дээшлүүлэх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг шинээр ажилтан бэлтгэх мэргэжлийн сургалттай хамтатган жил бүр явуулна.

5.3.2 Инженер, техникийн болон удирдах ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэхдээ: аж ахуйн газар, яам, тусгай газар, их сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллагын тусгай курс (семинар-т суралцуулах хэлбэрээр гүйцэтгэнэ.

5.3.3 Өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмж, химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэж байгаа зэрэг хөдөлмөрийн онцгой нөхцөлд ажиллах ажилтныг мэргэжлийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай хөтөлбөрөөр сургаж, үнэмлэх олгох ба зохих эрх аваагүй ажилтныг ажиллуулахыг хориглоно.

5.3.4 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг энэ асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу явуулна.

5.3.5 Үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан (дарга, захирал, эрхлэгч), шинээр аж ахуй эрхлэх гэж буй хүмүүс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай сургалтад хамрагдана.

5.3.6 Үйлдвэрлэл, цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн аюулгүй ажиллагааны сургалтад техникч, цэцэрлэгчин ажилтан нарыг улиралд нэг удаа, инженер, удирдах ажилтныг жилд нэгээс доошгүй удаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтад хамруулна.

5.3.7 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах, удирдлагаар хангах ажлыг тухайн байгууллагын дарга болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажил хариуцсан ажилтан хэсэг, нэгжид тэдгээрийн дарга хариуцна.

5.3.8 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тусгай шаардлага тавигддаг, аюултай ажил гүйцэтгэдэг ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг төрийн захиргааны уг асуудал хариуцсан байгууллага зөвшөөрсөн байна.

6. ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ХУВЦАС, ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

6.1 ЭРГОНОМИК ШААРДЛАГА

Хөдөлгөөн хийх үед хүний биеийн чөлөөт хөдөлгөөнийг хангах, өмсөх тайлахад хялбар, гадаад орчны нөлөөнөөс хамгаалах зэргийг нэгтгэсэн цогц шаардлага. Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна.

6.1.1 Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS

13688:2000” Монгол улсын стандартын шаардлагыг хангасан байна.

6.1.2 Бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай байна.

6.1.3 Хувцасны материал, дулаалга нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажуулсан байна.

6.1.4 Ажлын тусгай хувцас нь өвөл, хавар, намар болон зуны улиралд өмсөх хоёр төрөл байна. Өвлийн улиралд өмсөх хувцас нь -30°C-ээс -40°C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан дулаалга, доторлогоотой байна.

6.1.5 Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй байх.

6.1.6 Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх.

6.1.7 Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх.

6.1.8 Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх.

6.1.9 Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биеийн хүчний ачааллыг багасгахын тулд бололцооны хирээр бага байна.

6.2 АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦСАНД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага:

6.2.1. Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байна. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх.

6.2.2. Ус, тос, масло нэвтрүүлэхгүй байх.

6.2.3 Хөдөлгөөн хийхэд саадгүй. Биед дээд зэргээр таардаг байх.

6.2.4. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй. Хүний биед харшлахгүй байх.

6.2.5 Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна.

6.2.6. Өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх.

6.2.7. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.

6.2.8 Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх.

6.2.9 Өвдөг тохой, өгзөг хэсгээр нэмэлт давхарлагаатай байна

6.2.10 Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Оруулгын өнгө саарал байна.

6.3 ТУСГАЙ ХУВЦСАНД ТАВИХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

6.3.1 Хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалж ажлын тусгай хувцасны ашиглалт эдэлгээний хугацаа, дулаалга, өнгө өөр байна.

6.3.2 Ажлын тусгай хувцасны өнгийг 2-р хүснэгтэд заасны дагуу байх бөгөөд өвөл ба зуны улиралд өмсөх хувцсанд адил хамаарна.

Хүснэгт 6.1 Ажлын тусгай хувцас

Мэргэжлийн ангилал	Өвлийн хувцас			Зуны хувцас		
	Хүрэм		Өмд	Хүрэм		Өмд
	Үндсэн	Нэмэлт (оруулга)		Үндсэн	Нэмэлт (оруулга)	
Ажлын тусгай хувцас	Хөх	Тодруулагчтай Саарал	Хөх	Ногоон	Тодруулагчтай	Ногоон

6.4 ӨВЛИЙН ХУВЦАСНЫ ЗАГВАР

6.4.1 Хүрмийн загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

- Товчлоосоор салхи орох, дулаан алдахаас сэргийлэх даралт (планктай) дарсан;
- Дотрын дотроос салдаг үндсэн дулаалга болон дотроос салдаг нэмэлт дулаалгатай;
- Дотроос салдаг дулаалгыг тайлснаар хавар, намрын улиралд дотрын дотроос салдаг дулаалгатай өмсөнө. Дотрын дотроос салдаг дулаалгыг тайлснаар хүрмийн өнгө, гадар дангаараа үлдэж цэвэрлэгээ, угаах үед хялбар байх;
- Бүч бүхий малгайтай;
- Нэхий үстэй захтай;
- Ханцуйн үзүүрийн дотор талд салхи орохоос хамгаалах зангуу товчоор чангардаг байна;
- Бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалж дотор талдаа гүйдэг уяатай бүстэй байна;
- Далд товчлоостой;
- Энгэрийн дээд хэсэгтээ тагтай халаастай. Ташаандаа эзлэхүүнтэй ил халаастай;
- Энгэр, ар нуруунд гэрэл ойдог туузан оруулгатай;

6.4.2 Өмдний загвар, хийцэд дараах зохион бүтээлтийн хийцүүдийг тусгасан байна.

- Нуруугаар салхи орохоос хамгаалах комбинзон, бүсэлхийгээрээ сунаж агших чөлөөтэй өмсөх резинэн оруулгатай. Комбинзоны мөр нь уртасгаж, богиносгох зориулалттай резинэн мөртэй, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой өвдгөнд 2 хуниастай байна;
- Дотрын дотроос салдаг үндсэн дулаалга болон дотроос салдаг нэмэлт дулаалгатай байна. Дулаалгын шуумаг хэсэгт сүлжмэл манжеттай байна. Дотроос салдаг дулаалгыг тайлснаар хавар, намрын улиралд өмсөх бололцоотой болно. Дотрын дотроос салдаг дулаалгыг тайлснаар өмдний өнгө, гадар дангаараа үлдэж цэвэрлэгээ, угаах үед хялбар болгох;

- Өвдөгний хэсэгт давхарлагатай;
- Арын суудлын хэсэгт давхарлагатай;
- Ташааны оёдолд орсон халаастай;
- Хоёр хажуу талдаа тагтай эзлэхүүнтэй ил халаастай;
- Шуумаг хэсгийг зангуу товчоор нарийсгах боломжтой;
- Өвлийн дулаалгатай хүрэм, өмдний загвар, хийц, зохион бүтээлт нь 3-р зурагт үзүүлсний дагуу байна;



Зураг 6.1. Өвлийн хувцасны загвар

6.5 ЗУНЫ ХУВЦАСНЫ ЗАГВАР

6.5.1 Ажлын форм нь дан цамц байна.

- Эргэсэн хэвтээ, сорочкан захтай, ханцуй нь манжеттай байна;
- Энгэрийн дээд хөндлөн оруулгатай;
- Залгаа ханцуйтай;
- Далд цахилгаан товчлоостой;
- Форм нь 2 энгэртээ ил халаастай халаас нь даравчтай байхаас гадна ташаандаа далд ташуу 2 халаастай байна;
- Сугандаа агааржуулагч гуурстай;

6.5.2. Цэцэрлэгчийн өмдний хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

- Өвдөгний хэсэгт давхарлагатай, өвдгөнд хуниастай байх;
- Арын суудлын хэсэгт давхарлагатай;
- Ташааны оёдолд орсон халаастай, 2 хажуу талдаа халаастай, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой;

- Хажуу талд тагтай эзлэхүүнтэй халаастай;
- Шуумаг хэсгийг товчоор нарийсах боломжтой;



Зураг 6.2 Цэцэрлэгчийн зуны хувцасны хийц

6.6 АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАСНЫ МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

MNS 4010:2009, MNS 1835-6:2007, MNS ISO9237, MNS 1835-7:2007, ISO:12947, MNS 1835-3:2007, MNS 4010-2009, MNS 4010-97, MNS 1835- 5:2007, MNS 1835-9:2007, MNS 4072-88, MNS 4069-88, MNS 4070-88 стандартуудын дагуу байна.

6.7 АЖЛЫН ХУВЦАСНЫ ХЭМЖЭЭ

6.7.1 Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно.

6.7.2 Ажлын хувцасны хяналтын хэмжээг хүний өндөр, цээж болон бэлхүүсний тойргийн уртаар тодорхойлно.

6.7.3 Хувцасны хэмжээг тогтоохдоо хүн тус бүрээс 2 удаа хяналтын хэмжээг авч гүйцэтгэнэ.

6.7.4 Хувцасны суултыг хангах хэмжээг пиктограммаар үзүүлэх ба хүний биеийн өндөр, цээжний бүслүүр, бүсэлхийн тойрог, өгзөгний тойргийн хэмжээг тавьсан байна.

6.7.5 Өндөр, цээжний болон бэлхүүсний тойргийн уртын хэмжээ 1-р хүснэгтэд заасантай

тохирч байна.

6.7.6 Ажлын хувцасны хэмжээг тэмдэглэх жишээг дараах байдлаар үзүүлэв. 7.7.7 Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно.

Хүснэгт 6.2 Хувцасны хэмжээний хүснэгт

Биеийн өндөр (рост)	Биеийн өндрийн хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см	Цээжний тойргийн хэмжээ (размер)	Цээжний тойргийн Хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см
146,152	146....155	88, 92	86 ... 94
158,164	155....167	96, 100	94.... 102
170, 176	167....179	104, 108	102...110
182, 188	179....191	112, 116	110....118
		120, 124	118... 126
		128, 132	126....134

Хүснэгт 6.3 Эрэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа

Эрэгтэй хүний хэвийн хэмжээ	Хэвийн размер	Том размер
	40 42 44 46 48 50 52 54	56 58 60 62 64
Цээжний	80 84 88 92 96 100 104 108	112 116 120 124 128
Өндрийн	158 164 168 171 177 180 182	184 186 186 187 187
Бэлхүүсний	68 72 76 80 84 88 92 98	102 108 112 118 122
Гарын урт	56 57 58 59 60 61 62 63	64 65 66 67 68
Хөлийн урт	71 73 74 76 78 79 80 81	82 83 83 83 83

Хүснэгт 6.4 Эмэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцаа

Эмэгтэй хүний хэвийн хэмжээ	Хэвийн размер	Том размер
	36 38 40 42 44 46 48	50 52 54
Цээжний	84 88 92 96 100 104 110	116 122 128
Өндрийн	168 168 168 168 168 168 168	168 168 168
Бэлхүүсний	66 70 74 78 82 86 92	98 104 110
Таазны	91 94 98 102 105 109 114	120 125 131
Бэлхүүснээс хөлийн ул хүртэл хэмжээ	106 106 106 106 106 106 106	106 106 106

6.8 БУДАГ, ШОХОЙН АЖЛЫН ҮЕД ӨМСӨХ ХУВЦАС

6.8.1 Будаг, шохойтой харьцаж ажиллах үед тусгай зориулалтын нэмэлт хувцсыг хэрэглэнэ.

6.8.2 Уг нэмэлт хувцас нь хайлуулан ээрэх аргаар гаргаж авсан нэхээсгүй материал ТҮВЕК байна.

6.8.3 Будаг, шохойн хувцас нь ажлын тусгай хувцасны гадуур өмсөж хэрэглэх бөгөөд механик үйлчлэл, үрэлт, тостой нөхцөлд өмсөж хэрэглэхгүй бөгөөд зөвхөн будаг, шохой, хор цацах ажлын үед өмсөнө.

6.8.4 Будаг,шохойн хувцасны хийц, загвар, материал нь хөдөлгөөний чөлөөт байдлыг хангах, хөнгөн, биед эвтэйхэн бүх төрлийн будаг үл нэвтрүүлэх шинж чанартай байна.

6.8.5 Будаг, шохойн үед өмсөх хувцсанд угаалга, цэвэрлэгээ хийхгүй бөгөөд ажилтнуудад жилд нэг удаа олгоно.

6.8.6 Будаг, шохой нэвчихээс биеийн бүх хэсгийг хамгаалах зориулалт бүхий комбинзон байна.

6.8.7 ТҮВЕК-ийн гадаргуугийн жин нь 41гр/м² зузаан нь 5.4 мм статик цэнэгжилт үүсэхгүй,

агаар нэвтрүүлэхгүй байна / Зураг 3.3/.

6.8.8. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох үлгэрчилсэн жагсаалт (Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2002 оны 122 тоот тушаал.):

- Тухайн ажилтан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох хэд хэдэн нөхцөлд ажиллаж байвал заагдсан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрлийг давхардуулахгүйгээр олгоно;
- Шаардлагатай тохиолдолд жагсаалтад заагдаагүй ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нэмж олгож болно;
- Иргэний хамгаалалт, байгалийн гамшиг, осол, гал түймрийн үед ажиллах хүмүүст ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалтыг эрх бүхий холбогдох байгууллагууд нь ажлын өвөрмөц онцлог, шаардлагыг харгалзан иж бүрнээр нь тусган баталж мөрдөнө;



Зураг 6.3 Будаг шохойн хувцас

6.9 АШИГЛАЛТЫН ХУГАЦАА

6.9.1 Ашиглалтын хугацааг дараах хүчин зүйлээс хамааруулан үзнэ. Үүнд: цэвэрлэгээ, өнгө гандах, хэмжээний өөрчлөлт зэрэг болно.

6.9.2 Ажлын хувцасны эдэлгээний, ашиглалтын хугацааг байгууллагын захирлын тушаалаар батлуулж мөрдөнө.

6.9.3 Ажлын тусгай хувцас нийлүүлэгч аж ахуй нэгж, үйлдвэрлэгч нь ашиглалт эдэлгээний явцад хувцасны чанар, үр ашигт орох өөрчлөлт нь заасан хугацаанд энэ стандартын шаардлагад нийцсэн хувцсыг нийлүүлнэ. Ашиглалтын дурдагдсан хугацаанд хувцасны чанарыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.

6.9.4 Ажлын хувцасны ашиглалт, эдэлгээний хугацаанд худалдан авсан үнэ, чанар хийц болон байгаль цаг уур, гэнэтийн хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалан нэмэлт өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлтийг тухайн үеийн үүссэн нөхцөл байдлыг дүгнэн компанийн техникийн комисс тогтооно.

6.10 ЦЭВЭРЛЭГЭЭ

6.10.1 Ажлын тусгай болон энгийн хувцсыг энгийн ба химийн аргаар цэвэрлэх боломжтой байна.

6.10.2 Ус үл нэвтрүүлэх, ус-тос үл нэвтрүүлэх, үл цахилгаанжих нэмэлт хамгаалах чадварын үзүүлэлтүүд нь 5 удаагийн угаалтын дараа анхны шинж чанараа хадгалж байх ёстой.

6.10.3 Химийн болон энгийн цэвэрлэгээний дараа ажлын хувцасны материалын хэмжээний өөрчлөлт урт ба өргөнөөрөө 3 хувиас хэтрэхгүй байна.

6.11 ТЭМДЭГЛЭГЭЭ

6.11.1 Ажлын тусгай хувцас бүр компанийн нэрийн товчилсон үсгүүдийг тэмдэглэсэн тэмдэглэгээтэй байна.

6.11.2 Захиалагч талын хүсэлтээр алба, салбар, хэлтэс, нэгж, хэсгийн нэр, логог

тэмдэглэгээнд оруулж болно.

6.11.3 Компанийн нэрийн товчилсон үсгүүдийг илэрхийлсэн хүрмийн зүүн энгэр болон ар нуруун дээр 2 газар, нүдэнд харагдахуйц тод бөгөөд ойлгомжтой байх.

6.12 АЖЛЫН ГУТЛЫН СТАНДАРТ

6.12.1. Практик үүрэгт нийцэж буй эсэх

- Хүйтэнд тэсвэртэй;
- Бат бөх;
- Халтирдаггүй;
- Цахилгаанд дамжуулдаггүй;
- Тос болон усанд тэсвэртэй материалтай;

6.12.2 Эргономикийн үзүүлэлтэд нийцсэн эсэх


- Хөнгөн гэхдээ ажлын онцлогоос шалтгаалж төмөр хатуулгатай;
- Ул арзгар, зузаан халтирахгүй байх;
- Хөдөлгөөнд саадгүй түрийний зохион байгуулалттай;
- Хүйтэн халууны зохицуулагчтай;

6.12.3 Тусгай зориулалтын гуталд тавигдах шаардлагад нийцсэн стандартуудыг Европын холбооны улс болон Олон улсын нэгдсэн стандартуудын

шаардлагад нийцсэн гутлыг өмсөхөд ажлын бүтээмж нэмэгдэхээс гадна ослын үед гарах хохирлыг бууруулна.

6.12.3.1 Тусгай зориулалттай гутал ба хамгаалалттай гутлын бүтэц

EN ISO 20345: 2004 стандартыг хангасан гутал (200Ж энергитэй цохилт болон 15000Н хүчээр үйлчлэхэд тэсвэртэй). **EN ISO 20347: 2004** Үйлдвэрээс шалтгаалах бэртэл гэмтлээс хамгаалах, үйлдвэрийн орчин нөхцөлд тохирсон гутал. Хамрын хатуулга нь ган биш ч цахилгаантай ажиллах үед, ус болон тостой орчинд аль эсвэл төрөл бүрийн химийн бодис ба шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй байна. **SB-200Ж** үйлчлэлд тэсвэртэй мөн **S1, S2, S3, S4, S5**-тэй үзүүлэлтийг хангасан.



Зураг 6.4 Цэцэрлэгжүүлэлтийн хөдөлмөр хамгааллын гутал

6.13 ГАРЫН ХАМГААЛАЛТ БЭЭЛИЙ

6.13.1 Ангилал: Гар хамгаалах хэрэгслийг хийц, бүтэц, зориулалтаар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Механик үйлчлэлээс хамгаалах;
- Химийн бодисоос хамгаалах;
- Дулааны үйлчлэлээс хамгаалах;
- Цахилгаан хүчдэлээс хамгаалах;
- Доргионоос хамгаалах;

6.13.2 Ерөнхий шаардлага

Гар хамгаалах хэрэгсэл нь энэ стандартад үзүүлсэн тэмдэглэгээ болон MNS 4931: 2000 стандартын шаардлагыг хангасан байна. Үйлдвэрлэлийн ба техникийн үзүүлэлтийн баримтыг үндэслэсэн.

6.13.3 Тусгай шаардлага

1. Бээлий болон түүний баглаа боодол дээр тэдгээрийн зориулалт, ашиглалтын зааврыг бичсэн байна.
2. Бээлийг зориулалтаар нь ашиглахад гарын арьсанд сөрөг нөлөөлөл, цочрол үзүүлэхгүй байна.
3. Бээлий нь хөнгөн, гар, хурууны хөдөлгөөнд саад дарамт учруулахгүйгээр хийгдсэн, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлагад нийцсэн байна.

7. АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ, ТҮҮНИЙ ИЖ БҮРДЛИЙН ШААРДЛАГА

7.1. АНХНЫ ТУСЛАМЖ

Анхны тусламж гэдэг нь аливаа осол гэмтэл, биеийн болон сэтгэл зүйн гэнэтийн хямрал, өвчлөлийн үед мэргэжлийн эмч ирж, эсвэл эмнэлгийн байгууллагад хүргэж мэргэжлийн тусламж үзүүлэхээс өмнө гарын доорх материал ашиглаж, цаг алдахгүйгээр өөртөө болон бусад хүнд үзүүлж байгаа тусламжийг хэлдэг. Гарын доорх материал нь хамгийн цэвэр, тохиромжтой зүйл байх ёстой. Тусламжийг цаг алдахгүй, зөв аргаар үзүүлэх нь хүний амь насыг аврах, тухайн гэмтэл, өвчлөлөөс үлдэж болох үлдэц, хүндрэлийг багасгаж, эдгэрэлтийг түргэсгэхэд гол зүйл учраас хүн бүр анхны тусламжийн зохих мэдлэгтэй байх хэрэгтэй. Ер нь анхны тусламжийг үзүүлэхэд анхаарах гол зүйл бол нөхцөл байдлыг зөв үнэлж, зөв аргаар, цаг алдахгүй хүргэх нь чухал.

7.1.1 Тусламж үзүүлж байгаа хүн

7.1.1.1. Анхны тусламжийн менежментийн дөрвөн зарчим байдаг.

1. Тайван байх. Өөрийгөө болон гэмтсэн хүн, аливаа гэрч ажиглагчийг эрсдэлд оруулахгүй байх ёстой.
2. Нөхцөл байдлаас хамаарч өвчтөнд аль болох аюулгүй байдлаар дөхөж очно.
3. Өвчтөнийг удирдаж ажиллана.
4. Ажлыг дэс дараатай хийж гүйцэтгэнэ. Анхны тусламжийг хэрхэн үзүүлэх нь тухайн үед үүссэн нөхцөл байдал, орчин болон гарын доорх материал зэргээс хамаардаг. Анхны тусламжийг зориулалтын материалгүй ч үзүүлж болно. Гэхдээ материал ашиглан, ямар хэлбэрээр үзүүлэхээс үл хамааран дээрх зарчмуудыг мөрдөнө.

7.1.2 Тусламж үзүүлэх дараалал

7.1.2.1 Анхны тусламж үзүүлэх дөрвөн шат дараалал байдаг.

1. Орчны аюулгүй байдал болон тухайн тусламж шаардлагатай байгаа хүний байдлыг үнэлж, оношилно.

2. Энэ үнэлгээндээ тулгуурлан ямар тусламж, хэрхэн үзүүлэхээ шийдвэрлэнэ. Яаралтай хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дэс дарааллаа хурдан төлөвлөнө.
3. Төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ.
4. Үзүүлсэн тусламжийн нөлөөг үнэлж дүгнэн, өвчтөний байдлыг анхаарч асрамжилна.

Осол гэмтлийн үед нөхцөл байдал амархан өөрчлөгдөж, эхний удаа сайн мэдэгдээгүй гэмтэл, өөрчлөлт илэрч болох тул дахин үзэж, шаардлагатай тусламжийг үргэлжлүүлэн үзүүлнэ.

7.1.3 Анхны тусламжийн том хэмжээтэй иж бүрдэл

Тусламжийг зөв аргаар, цаг алдахгүй хүргэхэд анхны тусламжийн иж бүрдэл чухал хэрэгтэй. Иж бүрдэлд байгаа зүйлүүд бүгд өөр өөрийн үүрэгтэй. Иж бүрдэл нь тусламжийн хайрцагт байх ба болзошгүй осол, гамшгийн бэлэн байдлыг хангах зориулалтаар байрлуулж, хэрэглэсэн материалыг нөхөж, бүрэн байлгах ёстой.

- 8.1.3.1 Анхны тусламжийн хайрцагт дараах зүйлс багтсан байх.
- 5-10 см-ийн ариутгасан эмнэлгийн боолт - 1 багц;
- ариутгаагүй боолт: 5 м-ээс 5 см, 5 м-ээс 10 см - тус бүр 2 хайрцаг;
- ариутгасан хөвөн - 50 гр;
- цус тогтоогч боолт- 1 ширхэг;
- хурууны боолт - 1 боодол;
- мохоо хайч хамгийн багадаа 13 см-1 ширхэг;
- ариутгасан салфетка - 2 сав баглаа;
- халуун хэмжигч - 1 ширхэг;
- даралт хэмжигч -1 ширхэг;
- чимхүүр -1 ширхэг;
- үрэвслийн эсрэг эм 10;
- хос резинэн бээлий- 1 хос;
- иодын спиртийн уусмал 5% - 10 мл (50 мл);

7.1.3.1 Тусламжийн хайрцагт байх зүйлсийн ашиглалт

- Иод, спиртийн уусмал нь үүссэн шархны ирмэгийг эмчлэх замаар зураас, үрэлт, шархыг ариутгах зорилгоор ариутгагч бодис болгон гаднаас нь ашигладаг халдваргүйжүүлэгч;
- Ариутгасан эмнэлгийн боолт, нэг багц. Тусгай сав баглаа боодол нь хадгалалтын бүх хугацаанд ариутгалыг баталгаажуулдаг. Энэ нь ил шарх, боох зориулалттай;

- Эмнэлгийн ариутгаагүй боолт нь зөвхөн илрээгүй шарханд хэрэглэнэ. Боолтыг бэхлэхийн тулд боолт ашиглаж болно;
- Ариутгасан хөвөн нь боолт хийхэд мөн хөвөн самбайгаар хийхэд ашигладаг;
- Цус тогтоогч боолтыг гүн шарх, зүсэлт үүссэн үед цус алдалтаас, цусанд бохир дамжихаас сэргийлж хэрэглэнэ;
- 13 см-ээс багагүй мохоо хайч нь боолт, түүнчлэн анхны тусламжийн үед шаардлагатай бол хувцсыг огтлох зориулалттай;
- Ариутгасан салфетка нь арьсыг эмчлэхэд ашигладаг (шархны гадаргуу дээр наалддаггүй), үүнээс гадна хувийн эрүүл ахуйн бүтээгдэхүүн болгон ашиглаж болно.
- Халуун хэмжигч нь тухайн хүний биеийн хэмийг хянаж үзнэ;
- Даралт хэмжигч нь зүрхний үйл ажиллагааны хэвийн байдал, цусны даралтыг хянах
- Чимхүүр нь арьсанд шигдсэн зүйлийг авах зориулалттай;
- Үрэвслийн эсрэг эм, даралтны эм, халуун бууруулах эм зэргийг тус бүр 10 ширхэг байж болно;



Зураг 7.1 Анхны тусламжийн хайрцаг



Зураг 7.2 Анхны тусламжийн хэрэгсэл

7.2. АНХНЫ ТУСЛАМЖИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

7.2.1 Амь насанд аюултай, хүнд, хөнгөн осол гэмтэл нь хэдхэн секунд, хормоор хэмжигдэнэ. Гэмтэгсдэд үзүүлсэн анхны тусламжийн арга, хэлбэр, цаг хугацаа, чанараас шууд хамаардаг. Хүн бүр ямар ч үед осол гэмтэлд өртөгсдөд эмнэлгийн анхны тусламжийг хурдан хугацаанд үр дүнтэй үзүүлэх арга барилыг эзэмшсэн байх шаардлагатай. Анхны тусламж үзүүлэхдээ аль болох тайван, ухаалаг, нягт нямбай, сандарч тэвдэлгүй байж, хурдан хугацаанд найдвартай хийх арга дадлыг эзэмшсэн байвал зохино.

7.2.2 Анхны тусламжид чангалуур, даралттай боолт хийж цус тогтоох, шархыг цэвэрлэж, цэвэр боолт тавих, хугарч гэмтсэн мөчийг гарын доорх зүйл (банз, таяг, саваа, модны мөчир, нарны хаалт гэх мэт) хэрэглэж чиг тавин хөдөлгөөнгүй болгох,


зохиомол амьсгал, зүрхний иллэг хийх зэргээр анхан шатны тусламжийг үзүүлж эмнэлэгт хүргэнэ. Анхны тусламж үзүүлэхдээ:

- Хариулттай эсэхийг шалгах хэрэгтэй;
 - Энгийн команд өгөх - нүдээ нээгээрэй, миний гарыг атга, мэддэг бол нэрээр нь дуудах гэх мэт;
- Эхлээд тусламж яаралтай дуудах;
 - Та ганцаараа чанартай тусламж өгөх боломжгүй тул хавь ойрд байгаа дэм болох хүмүүсийг хашгирч дуудна;
 - 103 дууд, тусламжаа үргэлжлүүлж үзүүлнэ. Хүн бүр дээрх анхны тусламжийн аргуудыг мэдэх шаардлагатай;

7.2.3 Цус алдсан үед үзүүлэх анхны тусламж

Насанд хүрсэн хүний биед дунджаар 5 литр цус байдаг. Цус алдалтыг гадуур ба дотуур гэж ангилдаг. Дотуур цус алдалт нь аюултай бөгөөд анхны тусламж үзүүлэх болон оношлоход төвөгтэй байдаг. Гадуур цус алдалтыг артерийн судасны, венийн судасны, хялгасан судасны гэж ангилна.

7.2.4 Артерийн судасны цус алдалтын үед цус нь тод улаан өнгөтэй байх бөгөөд хүчтэй олгойдож лугшилтаар гардаг. Энэ үед цус гарч байгаа шархны дээд хэсэгт судсан дээр эрхий хуруу буюу дөрвөн хурууны өндгөөр ясанд нь тултал чанга дарж, дарсан хэсгийнхээ дээхнэ талаар гарт ойр байгаа зүйл (уяа, бүс, даавуу, алчуур гэх мэт)-ээр чанга бооно. Цус алдалт зогсохгүй бол шархны дээд хэсгээр чангалуур тавих бөгөөд зориулалтын резинэн чангалуур байхгүй үед бүс, тэлээ зэрэг гарын доорх материалыг ашиглана. Чангалуур тавихдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Чангалуур дор зөөлөн даавуу, бинтийг жийрэг маягаар тавьж арьс болон зөөлөн эд хавчигдах, хумигдахаас хамгаална. Чангалуурыг 2 цагаас илүү хугацаанд тавьж болохгүй бөгөөд чангалуур тавьсан цаг хугацааг тодорхой бичиж унаж хаягдахгүйгээр хавчуулсан байх шаардлагатай.



Зураг 7.3 Артерийн судасны цус алдалтын үед чангалуур тавьж боох

Дээрх хугацаанд эмчийн тусламж авч чадахааргүй бол чангалуурыг хэдэн минут суллах ба тэр үедээ цус алдсан шархнаас дээхнүүр судас дээр хуруугаараа дарж өгөхийг мартаж болохгүй. Чангалуурыг буруу тавих буюу хэт удаан байлгавал судас, мэдрэл гэмтэх, зөөлөн эд үхжих зэрэг хүндрэл тохиолдоно.

Үе мөчний яс хугараагүй боловч шархнаас цус алдаж байвал үенд нь хөвөн, бөс даавуу ивээд үеийг нугалан боож цус тогтоодог арга бас байдаг.



Зураг 7.4 Үе мөчний яс хугараагүй боловч шархнаас цус алдаж байх үеийн боолт хийх арга

7.2.5 Венийн судасны цус алдалтын үед цус нь хар хүрэн өнгөтэй байх бөгөөд тасралтгүй урсах маягаар удаан гардаг. Венийн судасны цус алдалтын үед даралттай боолт хийх буюу шархны доод хэсэгт дарна.

7.2.6 Хялгасан судасны цус алдалтын үед цус нь ягаан өнгөтэй байх бөгөөд гэмтсэн шархны хэсгээр нэлэнхийд нь нэвчих байдалтай гарна. Энэ үед шархны эргэн тойрон арьсыг иод, марганц, спирт гэх мэт ариутгалын бодисоор цэвэрлэж боолт хийнэ. Хэрэв цус нэвт шүүрч байвал ариутгасан бинтээр зузаан боогоод гэмтсэн мөчийг дээш нь сойно.

7.3 АМЬСГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА АЛДАГДСАН ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

Гэмтэгсдийн амьсгалын үйл ажиллагаа алдагдах үед нэн даруй яаралтай тусламж үзүүлэхгүй бол амь нас алдах аюултай. Усанд живэх, цахилгаан гүйдэл ба аянгад цохиулах, хүчилтөрөгч багатай (утаажсан цех, авто гарааш, гүн худаг, уурхай, автоцистерн гэх мэт/ орчинд удаан байх, цээж уушгины хүнд гэмтэл, амьсгалын зам бүтэн ба хагас бөглөрөх зэрэгт амьсгал хямарч зогсох аюултай. Амьсгал зогсох шалтгаануудыг мэдэж байвал яаралтай тусламж үзүүлэхэд хялбар юм.

7.3.1 Амьсгалын цочмог хямралын үед цээжин хэсгээр бие барьсан хувцсыг тайлж амьсгалын замыг чөлөөлөх арга хэмжээг авна. Үүний тулд нэг гараа хүзүүний ард, нөгөө гараа духан дээр нь байрлуулан хөнгөн маягаар толгойг нь хүчтэйхэн гэдрэг болгоно. Энэ үед хэлний угийн булчингууд сунах ба төвөнх дээш болж цагаан мөгөөрсөн хоолой чөлөөлөгдөнө.

7.3.2 Хэрэв гаднын биет (хоолны үлдэгдэл, нөж, ус, шороо, хиймэл шүд, шүдний хагархай гэх мэт зүйл) ам залгиурт тээглэсэн бол толгойг хажуу тийш эргүүлж, долоовор хуруугаа бинтээр ороож амны хөндийд байгаа гаднын биетийг авч цэвэрлэнэ.

7.3.3 Залгиурт тээглэсэн гаднын биетийг авахдаа өвчтөнийг бага зэрэг бөхийлгөж гарын алгаар дал хооронд нь хүчтэй цохино. Энэ үед зохиомол ханиалгалт үүсэж гаднын биет гадагшилна. Энэ арга үр дүн өгөхгүй бол тусламж үзүүлэгч ард нь зогсож баруун гараа хагас атгаж аюулхай орчимд нь байрлуулан зүүн гараараа

давхар барин хүчтэй хөдөлгөөнөөр хэвлийг доороос нь дээш шахаж өгнө. Өөрөөр хэлбэл хэвлийн хөндийн дээд хэсгийн даралт ихсэн огцом шахалтаар гаднын биет амьсгалын замаар гадагшилна.

7.3.4 Амьсгалын дээд замд (уушгинд) ус орсон үед өвчтөний толгойг унжуулж их биеэр нь баруун өвдөг дээгүүрээ дамнуулан байрлуулж зүүн гараараа толгойг нь гэдийлгэн, баруун гараар нуруун дээр нь 4-5 удаа цохиж усыг гадагшлуулна. Өвчтөн амьсгалахгүй байвал зохиомол амьсгал хийх хэрэгтэй. Зохиомол амьсгалыг амнаас аманд буюу амнаас хамарт хийнэ.

7.3.5 Амнаас аманд зохиомол амьсгал хийх арга: Гэмтсэн хүнээ нуруугаар нь хэвтүүлж хүзүүн доор нь цамц, дээл зэрэг зүйлийг ивээд толгойг нь арагш гэдийлгэж хүзүүг өвчүүтэй нэг шугамд тэгш байрлуулна. Гэмтсэн хүний аман дээр бинт (эсвэл нусны алчуур, даавуу, салфетик гэх мэт зүйл) тавина. Хажууд нь сөхөрч суугаад нэг гараа хэвтэж байгаа хүний духан дээр нь тавиад нөгөө гараараа эрүүнээс нь татаж амыг нээнэ. Амьсгалаа гүнзгий авч ам руу нь хүчтэй үлээнэ. Энэ үед өвчтөний хамрыг сайтар чимхэж байх хэрэгтэй. Эхний 3-5 үлээлтийг хурдан хийх ба нэг минутад 12-14 удаа хийвэл үр дүнтэй.

7.3.6 Амнаас хамарт зохиомол амьсгал хийх арга: Эрүү зуурсан, гэмтсэн зэрэг зарим тохиолдолд зохиомол амьсгалыг амнаас хамарт хийнэ. Ингэхдээ амнаас аманд хиймэл амьсгал хийхтэй адилаар өвчтөнийг байрлуулж нэг гараараа амыг нь сайн хааж (эрүүг сайн түлхэж, шүд, уруул сайн нийлсэн байхаар) амьсгалаа гүнзгий аваад хамар руу нь үлээнэ. Энэ үед амаар нь агаар орох, гарах боломжгүй байвал үр дүн өгнө. Хиймэл амьсгалыг хүүхдэд шууд ам, хамар руу зэрэг хийнэ.



Зураг 7.5 Залгиурт тээглэсэн гаднын биетийг авах арга



Зураг 7.6 Амьсгалын дээд замд ус орсон үед авах арга



Зураг 7.7. Амнаас аманд зохиомол амьсгал хийх арга

7.4 ЗҮРХНИЙ АЖИЛЛАГАА ГЭНЭТ ЗОГСОХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ АНХНЫ ТУСЛАМЖ

7.4.1 Зүрхний ажиллагаа зогсох үед арьс цайж, хүүхэн хараа томорч, судасны цохилт мэдрэгдэхгүй болж, амьсгал зогсох шинж тэмдэг илэрнэ. Энэ үед зохиомол амьсгал хийж зүрхэнд шууд бус иллэг хийнэ.

7.4.2 Зүрхний шууд бус иллэг хийх арга: Гэмтсэн хүнээ газар дээр, эсвэл хатуу тэгш зүйл дээр нуруугаар нь хэвтүүлж цээжнийх нь харалдаа сөхөрч суугаад өвчүүний доод хэсэгт гарын алгаа зөрүүлж давхарлаж тавина. Гарыг тохойн үеэр

нугалахгүйгээр гарын хүчээр биш цээж биеийнхээ жингээр жигд огцом дарна. Алга дарсан хэсэгт 3-5 см хонхойж байхаар минутад 60 удаа давтаж хийнэ.

7.4.3 Зүрхний шууд бус иллэгийг зохиомол амьсгалтай хослуулан хийхэд илүү үр дүнтэй байдаг. Нэг хүн тусламж үзүүлж байвал уушгинд хоёр удаа зохиомол амьсгал өгч, 15 удаа зүрхний шууд бус иллэгийг хийнэ. Өвчтөний далан доор хувцас буюу бусад зүйл ивж толгойг нь гэдрэг болгон амьсгалын замыг чөлөөтэй байлгавал зохино.

7.4.4 Хоёр хүн тусламж үзүүлж байвал нэг нь зүрхний шууд бус иллэгийг хийж доош нь дараад буцаах үед нь нөгөө нь зохиомол амьсгал өгөх маягаар ээлжлэн хийнэ. Нэг удаа амьсгал өгч, 4 удаа зүрхний шууд бус иллэг хийх нь зүйтэй.

7.4.5 Зүрхний шууд бус иллэг болон зохиомол амьсгалыг цаг хугацаанд нь зөв хийвэл зөвхөн зүрхний үйл ажиллагаа төдийгүй бусад эрхтний алдагдсан хэм хэмнэлийг ч сэргээдэг.



Зураг 7.8 Зүрхний ажиллагаа гэнэт зогсох үед үзүүлэх анхны тусламж

7.5. ЯСНЫ ХУГАРАЛ

Ясны бөх бат чанараас давсан гаднын хүчний үйлчлэлээр түүний бүрэн бүтэн байдал алдагдаж зөөлөн эд хамт гэмтэхийг хугарал гэнэ. Ясны хугарал нь ил, далд байхаас гадна яс нь зөрсөн, зөрөөгүй гэж 2 янз байна. Яс хугарах үед хүчтэй өвдөж тэр хэсэгт хавдаж, цус хурахаас гадна цус алдах явдал ч гардаг. Мөн хөл, гарын хугарсан хэсгээр муруй харагдана. Яс хугарсан хэсгийг аль болох хөдөлгөөнгүй байлгах нь чухал бөгөөд хэрэв хөдөлгөвөл хугарсан хэсэгт зөөлөн эд, том судас хавчигдаж улмаар гэмтлийн шоконд орж ухаан алдаж болно.

Ил хугарлын үед шарханд ясны хэлтэрхий орохоос болгоомжлох нь зүйтэй бөгөөд тэгшлэх, засах гэж оролдохын хэрэггүй. Шархыг цэвэр даавуу, бинт зэргээр боож цусыг яаравчлан тогтоох арга хэмжээ авах шаардлагатай. Өвчин нэмэгдсээр ухаан алдаж болзошгүй тул өвчин намдаах эм өгөх зэргээр түүний эсрэг арга хэмжээг хамт авна. Мөч хугарсан бол чиг барьж бооно. Ингэхдээ мод, хүрз, нарны хаалт, фанер, самбар, мөчир зэрэг гар дор байгаа хатуу зүйлийг ашиглах нь зүйтэй. Чиг барьж боохдоо зөөлөн материалыг зузаавтар жийрэглэж өгвөл зохино.

7.5.1 Гар, хөлийн яс хугарсан үед үзүүлэх анхны тусламж

Ясны хугарлын дотор дээд, доод мөчний хугарал 65-70 хувь тохиолддог. Гэмтэл бэртлийн үед гэмтсэн мөч эрхтнийг хөдөлгөөнгүй байлган, цаашид тээвэрлэн эмнэлэгт хүргэх асуудал маш чухал юм. Гар, хөлийн яс хугарсан үед аль болох

хөдөлгөөнгүй байхаар чиг тавьж боох хэрэгтэй. Хөдөлгөөнгүй боохдоо хугарсан хэсгийн дээд, доод хоёр үеийг оролцуулан боодог. Бэхэлгээ хийхийн өмнө чиг тавих зүйлээ хөвөн, бинт зэрэг зөөлөн материалаар бүрэх нь зөөлөн эд холгогдох, дарагдахаас хамгаалах ач холбогдолтой. Ясны төвгөр хэсэгт хөвөн, бинтээр жийрэг хийж өгөх хэрэгтэй. Ясны ил хугарлын үед ясны хэлтэрхийг буцааж хийх, татаж авахыг хориглоно.

Өвчтөний хувцсыг тайлах шаардлагатай бол эрүүл гар, хөлөөс нь эхэлж тайлна. Хувцас өмсгөхдөө гэмтсэн мөчөөс нь эхлэх нь зүйтэй. Өвчтөнийг дамнуурга дээр хэвтүүлэх буюу босгохдоо гэмтсэн мөчийг хөндөхгүйгээр зөөнө.

7.5.2 Дээд мөчний гэмтлийн үед гарыг сойж, хөдөлгөөнгүй болгохын тулд биетэй нь бэхэлж болно. Гарын шуу, бугалгын ясны хугарлын үед чигийг гадна ба дотор талаас нь тавина.

7.5.3 Дунд чөмгөний хугарлын үед хоёр ширхэг нарийн банз ашиглана. Нэг банз нь суганаас тавхай хүртэл, нөгөө нь цавинаас тавхай хүрсэн урттай байна. Гарын доорх материалгүй үед эрүүл хөлийг гэмтсэн хөлтэй нь хэд хэдэн саваагаар бэхлэн боож болно.

7.5.4 Шилбэний ясны хугарлын үед гадна ба дотор талд нь хоёр ширхэг банз бэхлэн, үе оролцуулан бооно.



Зураг 7.9 Дээд мөчний гэмтлийн үед гарыг сойх



Зураг 7.10 Дээд мөчний гэмтэл



Зураг 7.11 Шилбэний ясны хугарал



Зураг 7.12 Дунд чөмгийн хугарал

7.5.5 Аарцаг, нурууны яс хугарсан үед үзүүлэх анхны тусламж

Нурууны гэмтэлтэй өвчтөнийг заавал хавтгай зүйл дээр хэвтүүлэн тээвэрлэх ёстой. Хатуу банз мод байхгүй, зөвхөн зөөлөн дэвсгэр олдвол өвчтөнийг түрүүлгээ харуулан хэвтүүлж зөөвөрлөж болно. Биеийг нь нухахаас сэргийлэн хөнжил, пальто зэргийг дэвсэж бүсэлхий, тахим, хүзүүний хотгорт ивүүр зөөлөвч хийж өгнө.



Зураг 7.13 Нурууны гэмтлийн үед үзүүлэх тусламж

Аарцаг ясны гэмтлийн үед мөн хатуу юман дээр хэвтүүлж толгойн дор зөөлөн юм ивнэ. Хөлийг өвдөг, түнхээр нь нугалж бага зэрэг алцгар байрлалд хэвтүүлнэ. Үүний тулд гудас, хөнжил зэргийг хуйлж тахим доогуур нь ивж байрлуулна.

8. ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН БАЙРАНД ТОГТМОЛ ХИЙГДДЭГ АЖИЛ

8.1 ЦЭЦЭРЛЭГЧНИЙ АЖЛЫН БАЙРАНД НИЙТЛЭГ ХИЙГДДЭГ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

8.1.1 Цэцэрлэгчин ямар ч тохиолдолд мөрдөж ажиллах аюулгүй байдлын зөвлөмж. Үүнд:

- Гараа зүсэх, шавжид хазуулах, арьсыг цочроохоос хамгаалахын тулд үргэлж цэцэрлэгжүүлэлтийн бээлий өмс;
- Хурууныхаа оронд ухах зохих хэрэгслийг ашигла (жишээлбэл, хүрз эсвэл гар хүрз);
- Татрангийн эсрэг, ургамлын хачгийн эсрэг вакциныг цаг тухайд нь эмчтэй зөвлөлдөж хамрагдаж байх хэрэгтэй;
- Өөрт тохирох гарын багаж хэрэгслээ сонгоорой. Бариул дээрх хурууны үзүүр нь хэтэрхий бага эсвэл хэтэрхий их байвал цэврүү, булчингийн өвдөлт үүсэх болно;
- Гар багаж ашиглахдаа гар, бугуйгаа шулуун шугамд байлгана. Бугуйгаа нугалахад таны атгах чадвар сулардаг. Гар ба булчингуудыг илүү их хүчээр дасгал хийхэд хүргэдэг хэрэгсэл. Энэ нь зөөлөн эдийг ядрах, гэмтэхэд хүргэдэг;
- Гүйцэтгэх ажлын нөхцөл, чөлөөтэй хөдлөхөд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас заавал өмссөн байна (малгай, бээлий, өмд, цамц, гутал, амны хаалт, нүдний шил);
- Гар багажийг өөр хоорондоо шидэж дамжуулахгүй;

8.1.2 Цэцэрлэгчний үндсэн үүргийн дагуу мод, сөөг, цэцэг, зүлэг тарьж ургуулан арчлахад дараах ажлууд тогтмол хийгддэг.

- Холимог хөрс бэлтгэх;
- Ургамал услах;
- Ачиж буулгах;
- Ургамал бордох;
- Таналт тайралт хийх;

Иймд эдгээр ажлуудад аюулгүй ажиллагааны зүгээс мөрдөн ажиллах зөвлөмж боловсрууллаа.

8.1.2.1 Холимог хөрс бэлтгэх: Ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны дарааллыг мөрдөж ажиллана.

- Ургамал тарих холимог хөрс бэлтгэхдээ зориулалтын саванд, эсвэл салхины нөлөө багатай нөмөр газар гүйцэтгэнэ;
- Хөрсний холимог бэлтгэх ажлыг гүйцэтгэхдээ заавал иштэй багаж (хүрз, тармуур, шор, гэх мэт) ашиглана;
- Агаар дахь тоосонцрын эрсдэлийг бууруулахын тулд хольцыг бага зэргийн усаар шүршиж норгоно;
- Холимог хөрсийг нам даралтын хоолой ашиглан зөөлөн усална;
- Холимог хөрсийг богино зайд зөөхдөө хөдөлмөр хөнгөвчилж тэрэг, бага оврын техник ашиглана;

8.1.2.2 Ургамал усалж угаах, машинаар услах ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны дарааллыг мөрдөж ажиллана.

- Машин бүрэн зогссон үед жолооч зөвшөөрснөөр услах ажлыг эхлүүлнэ;
- Хоолой, шланк авах холбох, хураах ажлыг жолооч гүйцэтгэнэ;
- Ургамал услахдаа Ø50 шланкаар усалж байгаа бол 10 метрээс уртгүй байх, Ø25- Ø32 шланкаар ургамал усалж байгаа бол 15-20 метрээс уртгүй байх шаардлагатай. Хэрэв шланг уртасгах ба голчийн хэмжээ нэмэгдэхэд хоёр дахь ажилчныг хамтарч ажиллуулах шаардлагатай;
- Усалгааны шланкыг биед үүрэхгүй байх;
- Шлангаар 100 метр хүртэл зайд услах ажлыг гүйцэтгэнэ;
- Усалгааны шланкыг түрдэг тэрэг, бага оврын техникээр талбай хооронд зөөнө;
- Ургамал услахдаа шланкыг мушгихгүй, хөлд ороохоос хамгаалж анхаарч ажиллах хэрэгтэй;
- Шүршүүр бороожуулагч, суурь машинаар усалгааг хийх үед хөдөлгүүр ба шахуурт насосыг ажлын байдалд тохируулж байж усалгааг хийж эхэлнэ;
- Хувингаар усалгаа хийх тохиолдолд хүн тус бүр биеийн жинд тохируулан ус зөөх;

8.1.2.3 Ачиж, буулгах ажил ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны дарааллыг мөрдөж ажиллана.

- Эхлээд тээвэрлэлт хийх техникийг бүрэн зогссон үед тээвэрлэгч жолоочийг зөвшөөрөл өгсөн тохиолдолд ачиж буулгах ажлыг эхэлнэ;
- Машин, тоног төхөөрөмжид хамгаалалт байгаа эсэх;
- Машин, тоног төхөөрөмжийн нөхцөл байдал;

- Машин, тоног төхөөрөмжийг зөв хэрэглэж буй эсэх;
- Тавиур, тавцангийн тогтвортой байдал;
- Тавиур, тавцан дээрх эд материал аюулгүй хадгалж байгаа эсэх;
- Тавиур дээрх эд материалын ерөнхий төлөв байдал;
- Ажил гүйцэтгэх явцад дээрээс биет унах эрсдэл байгаа эсэх;
- Халтирч унах, бүдрэх, хөл гараа хавчуулах эрсдэл байгаа эсэх;
- Хаалт, хашилт, хамгаалалт тавьсан уу;
- Ажил гүйцэтгэж байгаа анхааруулах тэмдэг байрлуулна;

8.1.2.4 Ургамал бордох ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны дарааллыг мөрдөж ажиллана.

- Ажилтан хамгаалалтын ханцуй давсан резинэн бээлий өмссөн байх, ажил дуусгаад бээлийгээ усаар зайлж угаах хэрэгтэй;
- Ургамлын нэгдмэл тэжээлд эрдэс ургамал ба амьтны гаралтай бордоог бэлтгэхдээ зориулалтын саванд, эсвэл нөмөр газар салхинд хийсчихээс хамгаалж хийнэ;
- Бордоог бэлтгэх, хийх, савлах ажлыг гүйцэтгэхдээ заавал иштэй багаж (хүрз, тармуур, шор, гэх мэт) ашиглана;
- Бордоог богино зайд зөөхдөө хөдөлмөр хөнгөвчилж хувин, тэрэг, бага оврын техник ашиглана;

8.1.2.5 Ургамалд таналт тайралт хийх ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй ажиллагааны дарааллыг мөрдөж ажиллана.

- Цэцэрлэгчин ургамлын өргөс, хатсан мөчир, үзүүртэй ирмэг зэргээс хамгаалсан (савхин, давхар будагтай, берзинтэн аль нэг нь байж болно) бээлий өмсөнө;
- Хөдөлмөр хамгаалалтын хувцас нь салхинд хийсдэггүй материалтай байна. Энэ нь биеийн аль нэг хэсэг ил гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ;
- Ургамал танаж тайрах ажлууд нь үзүүртэй, иртэй багажтай харьцах тул гар багажийг зориулалтын (цэцэрлэгчний) цүнхэнд ирийг хамгаалж, хадгалж явна;
- Багаж тус бүртэй ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгааг авсан байх шаардлагатай;

8.1.3 Цэцэрлэгчний гүйцэтгэх чиглэлт ажлуудад өгөх аюулгүй ажиллагааны зөвлөмж

8.1.3.1 Цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөг тарих нүх ухах ажлын явцад үүсэж болзошгүй эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зааварчилгаа.

- Мод, сөөгийн нүхийг гараар ухах үед цэцэрлэгчин өөрийн биеийн өндөрт тохирсон иштэй хүрз ашиглана;

- Хурц иртэй жоотуу, царил ашиглаж байгаа тохиолдолд гараас амархан мултрахгүй иштэй багаж сонгоно;
- Хүрз, жоотуу, лоом, царил ашиглах явцад хүчтэй далайх, цохих үйлдлийг гүйцэтгэхдээ ойролцоо ажиллах хүнээс зай барьсан эсэх, өөрийгөө бүрэн хамгаалсан эсэхийг шалгаж үзэх хэрэгтэй;
- Нүх ухах багаж хэрэглэх явцад хад, чулуу их үсрэх аюултай тул цохих, бяцлах үйлдлийг их хүчлэхгүй гүйцэтгэх, модны нүхний байрлалыг өөрчилж ажиллах шаардлагатай;
- Төв суурин газар, барилга байгууламж, орон сууцны орчинд нүх ухах явцад цахилгааны утас, шугамын хоолой зэрэг илэрч болзошгүй тул ажлын зурагт тэмдэглэгээ байгаа эсэхийг шалгах хэрэгтэй;
- Цахилгааны болон шугамын хоолойн тэмдэглэгээгүй газар ажиллах явцад, цахилгааны утас, шугам, хоолой илэрвэл мод, сөөгийн нүх ухах ажлыг шууд зогсооно;

8.1.3.2 Цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөг суулгах ажлын явцад үүсэж болзошгүй эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Мод сөөгийг тарихдаа нахиа, мөчир үндсийг гэмтээлгүй суулгах бөгөөд, үндэс мөчрийн танах тайрах тохиолдолд зориулалтын секатор хэрэглэнэ;
- Секатор ашиглаагүй үедээ зориулалтын цүнхэнд хийж, газар тавьж байлгах бөгөөд гутлын түрий болон хувцасны халаасанд хийхийг хориглоно;
- Мод, сөөгийг суулгахдаа технологийн дарааллыг мөрдөж ажиллана;
- Ажил гүйцэтгэх явцад эргэх, тонгойх үйлдэл хийхдээ ойр байрлах ухсан нүхэнд хий гишгэж гэмтээхээс болгоомжлох;
- Мод, сөөгийг суулгахдаа иш, мөчирт нүд, нүүрээ хатгах, шүргэхээс болгоомжилж, суганд хавчуулах, титмийн хэсгийг нэг гараараа дарах маягаар өөрөөсөө тусгаарлаж ажиллана;
- Тарих модыг хүний хөлд тээглэхгүй, нүхний амсарт юм уу, нүхэн дотор түр байрлуулна;

8.1.3.3 Мод Үржүүлгийн газарт мод, сөөгийг үр мөчрөөр үржүүлэх, бойжуулах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Ажлын хувцас малгай, бээлий, амны хаалтыг бүрэн өмссөн байна;
- Ажилчид өөр хоорондоо харилцаа холбоотой ажиллаж, хийж буй ажлын технологийн зааварчилгааг авч ажиллана (хөрс боловсруулах, талбай бэлтгэх, тарилтын ажил гүйцэтгэх);
- Хөдөлмөрийн багажийг ашиглаж байх үедээ бусдад багаж дамжуулахдаа гараас гарт дамжуулах, эсвэл газар тавьж дамжуулна;
- Хамтран ажиллаж байгаа хүн тус бүртээ аюулгүй ажиллагааг тогтмол сануулна;

- Үр мөчрийг тарилтад бэлтгэж идэвхжүүлэгчид хийх үед бодисоос харшил авахаас урьдчилан сэргийлж биеийн арьсны аль нэг хэсгийн ил гаргахгүй тусгай зориулалтын хувцас өмсөнө;
- Ажлын багаж техниктэй харилцахдаа болгоомжтой байж аюулгүй ажиллагааны ерөнхий дүрмийг баримтлан ажиллана;
- Байгалийн үзэгдэл болох салхи шуурга,цас,бороо орсон тохиолдолд хорогдох байранд орох;
- Тарилтад бэлтгэх болон дэвтээсэн модны үрийг чих, хамар уруу хийх, амтлах зэргийг хориглоно;

8.1.3.4 Мод, сөөгийн тарьц, суулгацыг ухах, шилжүүлэн суулгах,тарилтад бэлтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Нүх, суваг шуудууг ухахдаа багажийг зөв барьж хөл гар, биеийн хэсгийг гэмтээхээс болгоомжилж ажиллана;
- Тарьц суулгацыг ухаж авах үедээ ажлын үндэс, мөчрийн гэмтээхгүй ухаж боож бэлтгэнэ;
- Мод сөөгийг тарихдаа үндэс, титмийг гэмтээлгүй холимог шороог хийхээс гадна хамтран ажиллаж буй хүний аюулгүй байдлыг давхар хангаж ажиллана;
- Ямар нэгэн багаж ашиглаж байгаа тохиолдолд шидэж чулуудахгүй, анхааралтай заавар журмын дагаж мөрдөж ажиллана;
- Хөдөлмөрийн багажийг ашиглах явцдаа хамтран ажиллаж байгаа хүн тус бүртээ аюулгүй ажиллагааг цаг тутамд анхааруулж байх;
- Талбайд ажилд гарахдаа ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгсэл, маск бээлийг тогтмол хэрэглэж ажиллана;

8.1.3.5 Тээвэрлэх, ачиж, буулгах, хадгалах

- Машин тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн ажлын зааварчилгааг авна;
- Үндэс, титэм хамгаалсан мод, сөөгийг ачихдаа 25 кг хүртэл жинтэй багцыг цэцэрлэгчин үүрч, тэвэрч зөөнө;
- 25кг –аас дээш жинтэй модыг ачихдаа бэхлэгчтэй өргөгч машин ашиглана;
- Мод сөөгийн үндэс,мөчир титмийг гэмтээлгүй ачиж тээвэрлэнэ;
- Мод сөөгийг тээвэрлэх үед болгоомжтой, анхааралтай ажиллаж, жолоочийн дохио,
- зааврыг дагаж автомашин зогссон үед ажил гүйцэтгэнэ;
- Модыг ачиж буулгах үед тавцан дээрээс хий гишгэх, халтирах, унах аюулаас болгоомжилж ажиллана;

8.1.3.6 Мод, сөөгийг тарьж ургуулах арчилгааны үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөхдөө гүйцэтгэх ажлын үе шат, цаг үед тохируулан ногоон байгууламжийн арчилгааны ажлын үеийн аюулгүй ажиллагааг өгнө.

8.2. ЦЭЦЭГ ТАРИХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

8.2.1 Хамгаалагдсан хөрсөнд болон ил талбайд нэг ба олон наст цэцгийг үр, булцуугаар үржүүлэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Энэ ажил нь гадаа орчинд дулаан жигдрээгүй үед хийгддэг тул хөдөлмөр хамгааллын хувцсыг тохируулан өмсөх хэрэгтэй;
- Хүлэмжийн нөхцөлд ажиллах явцад гарч, орохдоо температурын хэлбэлзэлтэй байх тул дулаан хувцас өмсөж байх;
- Хүлэмжийн нөхцөлд ажиллах үед түрийтэй гутал, урт ханцуйтай бээлий, биед чөлөөтэй хөдлөхөд хөнгөн хувцас өмсөнө;
- Цэцгийн үр булцууг тарихдаа, идэвхжүүлэгч, ариутгагч зэргийг ашиглахдаа амны хаалт хэрэглэж, үнэрлэхгүй, амтлахгүй зориулалт, зааврын дагуу ашиглана;
- “Гар багажтай ажиллах” үеийн аюулгүй ажиллагааны болон, ногоон байгууламжийн арчилгааны үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг авч ажиллана;
- Хүлэмжид ажиллахдаа цэцэрлэгчний сандал байнга ашиглаж байх;
- Удаан хугацаагаар хөл дээрээ сууж ажиллахгүй байх хэрэгтэй;
- Усалгаа хийгдсэн буюу хийх үед ургамал услах ажлын зааварчилгааг авч, усны гуталтай ажиллах хэрэгтэй;
- Ургамал хамгаалах, өвчин хортонтой тэмцэх, хор бодис хэрэглэсэн үед хүлэмжид ажиллахгүй байхыг бие биедээ анхааруулах шаардлагатай;



Зураг 8.1 Цэцэрлэгчийн сууж ажил гүйцэтгэхэд ашиглагдах сандал

8.2.2. Цэцгийн мандал байгуулах ажлуудын бэлтгэл ажил болон тарилт

- Цэцгийг ачиж зөөх, буулгах үед “Машин тоног төхөөрөмжтэй ажиллах” үеийн аюулгүй зааварчилгааг мөрдөх;
- Мандлын талбайг бэлтгэхдээ “Холимог хөрс бэлтгэх” үеийн аюулгүй зааварчилгааг мөрдөж ажиллах;

- Нийтийн эзэмшлийн талбай, барилга байгууламжийн орчинд ажиллахдаа замын хөдөлгөөн, орчны аюулгүйн байдлыг анхаарч ажиллах зааварчилгаа авч ажиллана;

8.2.3. Цэцэг, цэцгийн мандал арчлах үеийн аюулгүй ажиллагааны заавар. арчилгааны бүх үе шатнуудад

- Цэцгийн мандлыг арчлан ургуулахдаа ургамал услах, ургамал бордох, хөл ургамалтай тэмцэх, машин тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны заавар авч ажиллана;
- Нийтийн эзэмшлийн талбай, барилга байгууламжийн орчинд ажиллахдаа замын хөдөлгөөн, орчны аюулгүйн байдлыг анхаарч ажиллах зааварчилгаа авч ажиллана;

8.3 ЗҮЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

8.3.1. Зүлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, хөрс боловсруулах ажил хийж гүйцэтгэх үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа.

- Ажлын хувцас малгай,бээлий, амны хаалтыг бүрэн өмссөн байна;
- Ажилчид өөр хоорондоо харилцаа холбоотой ажиллаж,хийж буй ажлын технологийн зааварчилгааг авч ажиллана;
- Хөдөлмөрийн багажийг ашиглаж байх үедээ бусдад багаж дамжуулахдаа гараас гарт дамжуулах буюу газар тавьж дамжуулна;
- Хамтран ажиллаж байгаа хүн тус бүртээ аюулгүй ажиллагааг тогтмол сануулна;
- Байгалийн үзэгдэл болох салхи шуурга,цас,бороо орсон тохиолдолд хорогдох байранд орох;
- Хар шороо зөөж, ачиж буулгах үедээ тээврийн хэрэгсэл бүрэн зогсож аюулгүй байдлаа хангасан тохиолдолд ажлыг гүйцэтгэнэ;
- Тарилтад бэлтгэгдсэн үр нь мэрэгчдээс хамгаалсан хор, ариутгал хийгдсэн тул харшил, хордлогоос урьдчилан сэргийлж тусгай хувцас өмсөнө;
- Хэрэглэгдэх багаж хэрэгсэл,тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж ажиллана;
- Зүлэг хадаж, тайрах үед зүлгийн машин болон гар хадуурын бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагааг сайтар хангаж, шалгаж ажиллана;

8.4 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АРЧИЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

8.4.1 Хөл ургамал устгах үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Ажиллах үедээ ажлын хувцас өмсөх;

- Амны хаалт бээлий тогтмол хэрэглэх;
- Хөл ургамлыг устгах үед тармуур хүрз, гар багажийг шидэхгүй байх, хөл гар биеийн хэсгийг гэмтээхээс болгоомжлох;
- Хөл ургамлыг ачиж, зөөж, тээвэрлэх явцад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж жолоочийн дохио, зааврын дагуу тээврийн хэрэгсэл зөвшөөрөгдсөн газарт бүрэн зогссоны дараа ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ;
- Хөдөлмөрийн багаж ашиглаж байх үедээ эргэн тойрон хамтран ажиллаж байгаа хүмүүстээ аюулгүй ажиллагааг цаг бүрд сануулж байх;
- Нарнаас хамгаалж толгойн хамгаалах хэрэгсэл малгай тогтмол өмсөх бөгөөд шаардлагатай тохиолдолд норгож өмсөх;
- Байгалийн үзэгдэл болох салхи шуурга, цас, бороо орсон тохиолдолд хорогдох байранд орох;

8.4.2 Ургамал хамгаалал болон өвчин хортонтой, тэмцэх үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Янз бүрийн хортон шавжтай харьцах үед болгоомжтой ажиллах шаардлагатай.
- Өөрөөсөө хорт бодис ялгаруулдаг болон хортой үстэй шавж байдаг тул нүцгэн гараар барьж болохгүй;
- Өвчин хортон устгах хор болон бодис нь хүчтэй нөлөө үзүүлдэг. Хор болон бодисыг агуулсан савыг нээхдээ асгах, цалгих, үсэргэхээс болгоомжилж харьцах;
- Хөрс болон ургамлыг ариутгах бодис цацах үед тухайн бодисыг найруулахдаа эрх бүхий байгууллагын зааврын дагуу нарийн дэгийг баримтална;
- Тусгай хамгаалалтын хувцас, амны хаалт бээлий хэрэглэх;
- Эрх бүхий байгууллагын стандартыг мөрдөнө;
- Өвчин гарсан тохиолдолд эрх бүхий байгууллагын шинжилгээнд хамруулж үр дүнг тодорхойлно;
- Ариутгал болон устгал хийсэн тохиолдолд гар нүүрийг тогтмол угааж ариутгана;
- Хорт бодистой харьцах үед халуурсан, бие тавгүйрхсэн, биед ил харагдах том шарх байгаа тохиолдолд оролдохгүй дараагийн шатны тусламжийг авна;




Зураг 8.2 Хортон шавжтай харьцах үед болгоомжлох

8.4.3 Мод хэлбэржүүлэх танах үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Мод сөөгийг хэлбэржүүлэх танах ажилд гарахдаа нормын хувцасны стандартын дагуу өмсөх бөгөөд ингэснээр өөрийн болон бусдын хувцасны давирхай, тоос шороо болохоос хамгаална;
- Мод ургамал болон хөрсний тоосжилтоос өөрийгөө хамгаалж амны хаалт бээлийг тогтмол хэрэглэнэ;
- Өндөр ургасан мод, сөөгийг хэлбэржүүлэн огтлохдоо бэхэлгээ бүстэй ажиллана;
- Өндөр модыг танаж, хэлбэржүүлэх үед шат ашиглах, шатыг хөдөлгөөнгүй суурилуулсан үед гарч ажиллах хэрэгтэй;
- Ажлын явцад хөдөлмөрийн багажтай зөв зохистой харьцах шаардлагатай бөгөөд гараас гарт буюу газар тавьж дамжуулна. Мөн гэрээт ажилтнууд ажиллаж байгаа тохиолдолд үндсэн ажилтан давхар хяналт тавьж ажиллана;
- Хамт ажиллаж буй хүмүүсийн гар болон биеийн хэсгийг гэмтээлгүй аюулгүй ажиллах шаардлагатай бөгөөд хамт ажиллаж байгаа хүмүүстээ аюулгүй ажиллагааг байнга сануулна;
- Модыг огтлох, тайрах үед хатсан мөчир, хожуулыг бусдад аюул үүсгэхгүй бүрэн огтлох хэрэгтэй. Энэ нь урах, хатгах, зоох аюул үүсгэнэ;
- Зориулалтын тусгай багаж хэрэгслийг мэргэжилтний өгсөн зааврын дагуу хэрэглэнэ;



Зураг 8.3 Мод сөөгийг хэлбэржүүлэх танах



Зураг 8.4 Цэвэрлэгээний огтлол

- Цэцэрлэгжүүлсэн талбайд цэвэрлэгээний огтлолт хийх үед өндөр ургасан модыг буулгахдаа 2 талд нь адилхан цавчиж мөр гаргасан тохиолдолд аюулгүй талд уруу бэхэлгээ хийж эсрэг талаас нь хөрөөдөж унагаж байх;

8.5. ГАР БАГАЖТАЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

8.5.1 Гар багажтай ажиллах өдөр тутмын ажлын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Ажилд гарахдаа зориулалтын хувцас хэрэгслийг бүрэн өмссөн байх;
- Хэрэглэгдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эд ангиудыг бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж ашиглах;
- Багаж хэрэгслийг шидэж дамжуулж болохгүй. Багажийг дамжуулах тохиолдолд гараас гарт дамжуулах буюу шал болон найдвартай гадаргад тавих хэрэгтэй;
- Хөрөө, өрөм, трактор болон бусад дуу чимээ ихтэй багажтай харьцахдаа сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ;
- Мөчир огтлох, мод тайрах мэт ажил гүйцэтгэх үедээ хурц үзүүр ирмэгтэй зүйлд ойртох, тухайн ажлын явцад тоос шороо хөдлөх учир битүү нүдний шил зүүнэ;
- Огтлох тайрах багажаар ажиллах үед хөл, гар зүсэх, цавчихаас урьдчилан сэргийлж зөв дарааллаар ажиллаж байх;



Зураг 8.5 Гар багаж ашиглах

- Гар багаж ашиглахдаа өөрийн болон ойр орчимдоо хамтрах ажилтны аюулгүй байдлыг хангаж ажиллах, гар багажийг ашиглах, арчлах талаар асууж тодруулах зүйл гарвал ахлах ажилтнаас асууна;
- Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зөв зохистой байрлуулах, хураах, хадгалах хэрэгтэй;
- Ажилд гарахын өмнө ажил тус бүр дээр нэмэлт аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна;
- Гар багаж хүрз, тармуур, алх, сүх, хөрөө, гар хадуур, мөчрийн хайч, бахь, сантехникийн түлхүүр зэргийг дурдаж болох юм;
- Гар багажтай холбоотой аюул эрсдэл ихэвчлэн зүй бус хэрэглээ, зохисгүй ашиглалт,
- зориулалтын бус зүйлээр орлуулан хийсэн засвараас үүдэн гардаг;
- Багажийг ирлэх, ир солих шаардлагатай үед угсрах, салгах зөвлөмжийн дагуу ажиллах;



Зураг 8.6 Багажийг ирлэх, ир солих

- Гар багажийн аюулгүй ажиллагаа нь хийх ажилдаа тохирох багаж сонгохоос эхэлнэ;
- Багажийн бариул, их биедээ найдвартай бэхлэгдсэн, эсэх, ирмэг, өнцгийн бүрэн бүтэн байдлыг сайтар нягтлан шалгах хэрэгтэй;



Зураг 8.7 Ирмэг, хурц иртэй багаж

- Ажил дуусмагц багаж хэрэгсэл дээр санамсаргүй гишгэх, гар хүрэх зэргээс болгоомжилж зориулалтын байр саванд хурааж байх хэрэгтэй;

- Ирмэг, хурц иртэй багажийг хэзээ ч өөрийн бие рүү чиглэлтэй хэрэглэж болохгүй.
- Халаасандаа эд хэрэгслийг зөөвөрлөж болохгүй;
- Хоорондоо авч өгч, шилжүүлэх тохиолдолд гараас гарт гүйцэт бариулна;
- Мөчир огтлох, мод тайрах үед ойр орчмын өвс ургамлыг сайтар цэвэрлэж харагдах байдлыг чөлөөтэй болгож ажиллах;
- Ажиллаж байх үедээ өөрийн болон бусдыг аюулгүй байдлыг үргэлж анхааран ажиллана;


8.5.2 Моторт хөдөлгүүртэй багажаар ажиллах үеийн аюулгүй ажлын зааварчилгаа

8.5.2.1 Моторт багажуудтай ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1. Багажийн тохиргоог зааврын дагуу хийж гүйцэтгэсэн байна.
2. Багаж хариуцан авч ажиллах цэцэрлэгчин нь багажийн тохиргоо хийх, ажиллуулах дарааллыг сургалтаар авсан байна .
3. Багажийг үүрч, түрж, унаж хэрэглэх үед нэмэлт хувцас, тоноглолыг хэрэглэнэ (бүс, нүдний шил, малгай гэх мэт).
4. Багажийн ирийн эргэлтээс цэцэрлэгчин биеэ хамгаалж салхинд амархан хийсдэггүй материалтай өмд өмссөн байх хэрэгтэй.
5. Цаг уурын нөхцөлт тохируулж цэцэрлэгчин өөрийн биеийг салхин талд, багажийг салхины чиглэлийн эсрэг талдаа байрлуулж ажиллана.
6. Багаж нь шатах материалаар ажиллах тул галын аюулгүй ажиллагааны
7. зааварчилгааг мөрдөж ажиллана.
8. Моторт багажаар ажиллах үед ажлын талбайн норм баримталж бусдыг гэмтээхгүй байх.
9. Багажийн ир солих, засварлах үед ажлын талбараас тусгай аюулгүй цэгт багаж угсрах зааврын дагуу ажиллаж байх.



Зураг 8.8 Багажийг үүрч, түрж явах



Зураг 8.9 Багажийн ирийн эргэлт



Зураг 8.10 Ажлын талбайн норм баримталж бусдыг гэмтээхгүй байх

8.6 МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

8.6.1 Автомашин жолоодох үеийн хөдөлмөрийг аюулгүй байдлын зааварчилгаа

- Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийг баримтална;
- Жолооч бүр хүчин төгөлдөр эрх бүхий жолооны үнэмлэхтэй байна;
- Жолооч өөрийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслийн ариун цэвэр аюулгүй байдлыг бүрэн хариуцна;
- Жолооч техникийн аливаа эвдрэл гэмтэл, хэрэгцээт засварын талаар тогтмол мэдээлж байх хэрэгтэй;
- Өөрийн хариуцаж буй тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлэхийг хориглоно;
- Жолооч архи тамхи болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн тохиолдолд жолоо барихыг хориглоно;
- Бензин түлш, кислород зэрэг ил гал гарах шатамхай бодисыг ил задгай хадгалахгүй байх;
- Засвар үйлчилгээ хийх үедээ мэргэжлийн байгууллага, хүний заавар зөвлөгөөг авах бөгөөд тэдгээрийн хяналтад хийж гүйцэтгэнэ;

8.6.2 Машин механизм тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа.

8.6.2.1 Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 4.1.1, 6.1, 9.1.1, 9.1.4-т заасныг үндэслэн дараах журмыг мөрдөж ажиллана.

- Машин механизм, тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх, гарахын өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах;
- Машин механизм, тоног төхөөрөмж дээр ажиллах хүн тус бүр аюулгүй ажиллагааг ханган ажиллах;
- Машин механизм тоног төхөөрөмжийг хөдөлгөөнд оролцуулахдаа эргэн тойрон орчныг заавал нягтлах;

- Хөдөлгөөн хийхээс өмнө болон дууссаны дараа ачаа бараа болон хүмүүсийг буулгаж байх;
- Шатах тослох материалууд нь галын аюултай тул алхам тутамдаа анхаарал болгоомжтой байх;
- Засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байх;
- Хөдөлгөөнд оролцож байхад хамтрагч болон бусад хүмүүс зориулалтын бус суудалд суух болон зүүгдэхийг хориглох;
- Үйлдвэрлэлийн талбайд тогтсон маршрутын дагуу явна;
- Бүрэн бус тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцохыг хориглоно;

9. ЦЭЦЭРЛЭГЧИНД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ГЭМТЭЛ

9.1 ОСГОЛТ

9.1.1 ОСГОЛТЫН ҮЕИЙН АНХНЫ ТУСЛАМЖ

- Өвчтөний биеийн байдлыг үнэлэх- Ухаантай эсэх, гэмтэлтэй эсэх;
- Дулаан орчинд оруулах, хуурай халаагчид ойртуулахгүй;
- Хөлдсөн болон хүйтэн хувцсыг тайлах;
- Бүх биеийг дулаацуулж, зузаан хөнжил, даавуугаар хучих;
- Халуун цай, ус, кофе уулгах;
- Тухайн хөлдсөн хэсгийг гэсгээж дулаацуулах (гар, хөл, чих, хамар, нүүр);
- Биеийн хөлдсөн хэсгийг усанд дүрэх - 38°C- 41°C;
- Өвдөлт намдаах, тайвшруулах;



Зураг 9.1 Биеийн хөлдсөн хэсгийг усанд дүрэх



Зураг 9.2 Бүх биеийг дулаацуулах

9.1.2 ХӨЛДӨЛТ БОЛОН ОСГОЛТООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- Сул, чөлөөтэй хувцаслах “байцаа шиг” ингэснээр агаарын давхарга үүсэж дулааныг сайн хадгалдаг;
- Дээгүүрх хувцас нь салхи нэвтэрдэггүй байх;
- Давчуу багадсан гутал, чийгтэй бохир оймс өмсөхгүй;

- Малгай ороолт зүүж бээлий өмсөж хэвших;
- Дээрх зүйлс нь цэвэр даавуун, хөвөн, ноосон материалаар хийгдсэн байвал зөв;
- Хүйтэнд удаан хугацаагаар явахдаа мэдэж байгаа бол биеэ тосолж байх хэрэгтэй
- Салхинаас болгоомжилж байх, гадаа нойтон үстэй гарахгүй байх;
- Санамсаргүйгээр усанд унах зэргээр хувцсаа норговол нойтон хувцаснаасаа маш хурдан салж хуурай хувцас өмсөх хэрэгтэй;
- Хүйтний улиралд шаардлагатай бол 30-60 минут тутамд дулаацуулж байх хэрэгтэй;



Зураг 9.3 Хүйтний улиралд биеийн захын хэсгүүд болох чих, хамар, хацар, эрүү, гар, хөлийн үзүүрийн хөлдөлтүүд

9.2. ХАЛУУНЫ ЦОХИЛТ


9.2.1 Нарны болон бусад эргэн тойрны халуун нөхцөлд хүний дулаанаа зохицуулах чадвар алдагдаж, биеэс ууршуулах чадвар хүрэлцээгүй болж биеийн температур өсдөг нь халууны цохилт болно.

- Хүүхэд, өндөр настан болон зарим эм хэрэглэсэн (шээс хөөх, антигистам гэх мэт)
- хүмүүс өртөх нь их байна. Халууны цохилт нь дараах сонгомол 3 шинжээр илэрдэг;
- Халуун нэмэгдэх;

- Мэдрэлийн хямрал (үгээ солих);
- Арьс халуун, хуурай болох;

9.2.2 Халууны цохилтод авах арга хэмжээ

- Хэрвээ ухаантай бол сэрүүн газарт оруулж хувцсыг нь тайлж хэвтүүлнэ;
- Биеийн халууныг бууруулах арга хэмжээ авна;
- Давстай өтгөн цай бага багаар уулгана;
- Тусламж үзүүлж байхдаа амьсгалын байдлыг шууд ажиглаж, саад байгаа эсэхийг мэдэх хэрэгтэй. Амьсгалын замыг чөлөөл;
- Сэрүүн газар оруулна;
- Хөлийг жаахан өндөрлөж, нойтон алчуур толгойд нь тавина;
- Хувцсыг тайлж суга, цавь, шанаа, дагз, тахим зэрэг том судас явдаг газар хүйтэн жин тавьж ойр ойрхон солино;



Зураг 9.4 Халууны цохилтод орох

9.3 ТҮЛЭГДЭЛТ

Түлэгдэлт гэдэг нь халууны эсвэл бусад хурц туяанаас үүдэлтэй арьс, эрхтний эд анхдагчаар гэмтэхийг хэлнэ.

9.3.1 Дулааны түлэгдэлт / шингэн халуун зүйл болон халуун биетэд хүрсэн үед үүснэ/- ийн үед авах арга хэмжээ

- Галын дөлд түлэгдэж байгаа бол –ЗОГС-ХЭВТ- ӨНХӨР – гэсэн дарааллаар тусламж үзүүлнэ;
- Түлэгдэл үүсгэнэ хүчин зүйлийг биеэс холдуулах хэрэгтэй;
- Түлэгдсэн хэсгийн хувцсыг тайлах;
- Өөрөө түлэгдэхээс зайлсхийх;
- Наад зах нь 10-15 минутын турш хүйтэн цоргоны усны урсгалд хөргөх /хөргөх усны температур 15°C буюу 8°C-25°C байна;
- Цэвэр бентээр боож эмнэлэгт хүргэх;

- Арьсанд наалдах металл эдлэлийг бие-ээс салгах (ээмэг, бөгж, зүүлт, тэлээ гэх мэт);

9.3.2 Химийн түлэгдэл


- Химийн бодис нь нунтаг бол эхлээд сойзоор үлдэгдэл хэсгийг нь унагааж дараа нь усаар угаана;
- Химийн түлэгдэлтийн үед удаан хугацаагаар, их хэмжээний усаар угаана. Үүнд шүршүүр хэрэглэх нь зүйтэй;
- Оролцож буй химийн бодисыг тодорхойлно;
- Эмнэлэгт хүргэнэ;

9.3.3 Нүдний түлэгдэлтийн үед

- Физиологийн уусмалаар PH-ийг саармаг болтол зохих ёсоор угаах хэрэгтэй;
- Физиологийн уусмал 4 уут шаардлагатай;
- 15-20 минутын турш тасралтгүй угааж, цэвэр боолтоор боох хэрэгтэй;
- 20 минутын дараа өвдөлт хэвээр байвал эмнэлэгт очих шаардлагатай;

9.3.2 Цахилгааны түлэгдэлт


- Цахилгааныг унтрааж эх үүсвэрийг салгах хэрэгтэй;
- Өөрийн аюулгүй байдлыг санаж, цахилгааны эрчим хүчний эх үүсвэрээс өвчтөнийг салгах;
- Тусламж үзүүлэгч цахилгаан дамжуулдаггүй материал ашиглах, резинэн бээлий өмсөх хэрэгтэй;
- Тусламж үзүүлэгч өөрөө түлэгдэхээс зайлсхий;
- Үйлчлүүлэгчийг хэвтүүлж тээвэрлэх хэрэгтэй учир нь бүх биеэр гүйдэл гүйж амин чухал эрхтнүүдийн үйл ажиллагааг хямраадаг;



Зураг 9.5 цахилгааны эрчим хүчний эх үүсвэрээс өвчтөнөөс холдуулах

9.3.5 Түлэгдэлтэд дараах үйлдлүүдийг хэзээ ч хийж болохгүй: Шинжлэх Ухааны үндэслэлтэй тайлбарууд:

- Барааны саван түрхэх – хүйтэн гадаргуугаар хүрдэг учир өвдөлт түр намдаж байгаа мэт санагдана;
- Элсэн чихэр түрхэх – бактери нян нь чихэрлэг орчинд үрждэг. Иймд нянгийн тоог нэмэгдүүлэх болно;
- Уушгины улаан эм – бактери нянд тэсвэртэй шархыг бий болгодог. Түлэгдэлтийн улмаас хүнд үүсэх хордлогыг гүнзгийрүүлдэг;
- Хоромхон тос – зөвхөн өнгөц түлэгдэлтэд хэрэглэдэг;
- Өндөгний шар түрхэх – бактери нян нь үржих уураглаг орчныг бий болгоно. Иймд нянгийн тоог нэмэгдүүлэх болно;
- Хөлдүү мах – хүйтэн гадаргуугаар хүрдэг учир өвдөлт түр намдаж байгаа мэт санагдана. Түүхий болоогүй, бохирдол ихтэй байгаа тул халдвар шарханд шууд орох эрсдэлтэй;
- Амьтны цус – ариун бус. Амьтны цусанд агуулагдах нянууд шархаар дамжин хүний биед орно. Бактери, нян нь үржих орчин бий болгоно;
- Гутлын тос – дулааны түлэгдэлтийг химийн түлэгдэлт болгох хувиргадаг;



Зураг 9.6 Түлэгдэлтийн зэргээс хамаарах тусламжийн арга хэмжээнүүд

9.4. ХАМРЫН ЦУС АЛДАЛТ

Хамрын цус алдалт, цус алдах нь гэмтэл, цусны бүлэгнэлтийн алдагдал, артерийн даралт ихсэх өвчин ба бусад өвчнүүд, эсвэл биеийн хүчний ачааллын үед үүсдэг.


9.4.1 Шалтгаан нь

- Хамрын хөндийн салст бүрхэвчийн судасны бүрэн бүтэн байдал алдагдах нь цус алдалт үүсэхэд хүргэдэг шууд шалтгаан юм;
- Хамар дотор гаднын биет орж салст гэмтэх;

- Даралт ихсэх;
- Амин дэмийн дутагдал ба амин дэмгүйдэл;
- Хэт халах, наранд цохиулах, хөөрөх;
- Агаарын даралт эрс багасах үед үүсэх эмгэг (дааврын тэнцвэрт байдлын алдагдал ба жирэмсний үед);
- Хамрын нүхнээс цус урсах, эсвэл амнаас залгиур руу цус урсах нь хамрын цус алдалт эхэлснийг заах шууд шинж тэмдэг юм;
- Хэрэв цус алдалт ямар нэг өвчний шинж тэмдэг бол энэ эмгэгийг тодорхойлох хэрэгтэй;
- Ихээхэн цус алдсан үед бие сулрах, чих шуугих, нүд бүрэлзэх, чичрэх, толгой эргэх, зүрх дэлсэх зовирууд гардаг;
- Арьс салст цайж цонхийж болно;

9.4.2 Анхны тусламж

- Цус алдаж буй хүнийг бага зэрэг тонгойлгож суулгана;
- Цус гарч буй хамрын нүхээр 3% устөрөгчийн давхар исэл, эсвэл хүйтэн усаар норгосон хөвөн хийж хамрын нүхийг дарна. Дарсан чигтээ 5 минут болно;
- Хамрын орчимд хүйтэн усаар дүүргэсэн хүүдий, мөстэй жин тавина;
- Хамар дахь хөвөн цустайгаа хатаж авахад бэрхшээлтэй болбол дусаагуураар норгож болно;
- Цус гарч буй хүнийг босгож, эсвэл толгойг хүчтэй арагш нь гэдийлгэж болохгүй, учир нь цус залгиур луу орж, бөөлжиж болно;
- Хэрэв цус хүчтэй гарч байвал нэн яаралтай түргэн тусламж дуудах хэрэгтэй;



Зураг 9.7 Хамрын цус алдалтанд зөв арга хэмжээг авах

10. ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ АХУЙН ШААРДЛАГА

10.1 ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2008 онд батлагдсан хуулийн дагуу цэцэрлэгчийн зарчим, ажлын байранд тавигдах нийтлэг шаардлага, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлэн хангаж ажиллана. Үүнд: Аж ахуйн нэгж, байгууллага ажилтны тооноос хамааруулан

- Орон тооны ажилтан, алба, зөвлөлтэй байх;
- Эрсдэл өндөртэй ажлын байр бүрд эрсдэлийн үнэлгээ хийх;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн менежмент нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэлийн барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмж, химийн хортой, аюултай бодист тавих шаардлага;
- Ажилтныг ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;
- Ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах;
- Ажилтныг осол авааргүй эрүүл ажиллах сургалтад хамруулах;
- Ажил олгогчийн хүлээх үүрэг хариуцлага болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, давтан сургах асуудлыг хуульчилсан болно;

Хөдөлмөрийн чадвар алдалт:

- Өвчин эмгэг нь архаг удаан явцтай, эрхтэн бие мах бодийн тогтоц, үйл ажиллагааг гэмтээж доройтуулсны улмаас үндсэн мэргэжлийн ажлыг хийж чадахгүй болж, хийсэн эмчилгээнд засрахгүй байнгын архаг байдалтай болсныг хэлнэ. Стандарт: ХАА, ЭАН нэр томьёо MNS 4967:2000, MNS 4967:2000;
- Хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг ажлын үзүүлэлт тус бүрээр (MNS 5080:2001), хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллийг MNS 5080:2001, MNS 5107:2001, MNS 4990:2000, MNS 5002:2000, MNS 5106:2001, MNS 4967:2000 норм, стандартуудаар тодорхойлно;

10.2 ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ОРЧИН

10.2.1 АЖЛЫН БАЙР

MNS 6437:2014 мөрдөж ажлын байр нь шал, хана эрүүл ахуйн стандартад нийцтэл хангалттай угааж цэвэрлэх боломжтой материалаар хийсэн байна.

Ажлын байранд байгалийн хангалттай гэрэл тусч байна. Мөн цаг агаарын байдлыг тооцож, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй хөдөлмөрлөхөд хангалттай зохиомол гэрлээр ажлын байрыг тоноглоно. Ажлын байрны шуугиан Монгол Улсын стандартад тогтоогдсон шаардлагыг хангасан байна. Цэцэрлэгчний ажлын гүйцэтгэл нь

- Байнгын (Ажлын цагийн 50%с дээш хугацаа);

- Байнгын бус (Ажлын цагийн 50%- с доош хугацаа) орчинд явагддаг;
- Ахуйн байр MNS 5621:2000 стандартын дагуу байна;

10.2.1.1 Түр амрах өрөө

1. Цэцэрлэгчин халуун, хүйтэн уух шүүлтүүртэй ус, цай, кофе, нэг удаа хэрэглээний аяга байрлуулсан байна.
2. Нэг удаа хэрэглэх аяга, цай, кофе хадгалах тавиур байрлуулсан байна.
3. Амарч суух сандал , халуун хүйтэн зүйл тавих ширээ, тавиур байрлуулна.

10.2.1.2 Хувцас солих өрөө

1. Ажилчны хувцасны шүүгээг ажилчин тус бүрд нэг ширхэг байхаар тооцож хийнэ
2. Хувцас солих үед ашиглах сандал суурилуулсан байна.
3. Ажилчны хувцасны шүүгээ нь 3-4 тасалгаатай, өлгүүр дэгээтэй байна.
4. Хувцасны шүүгээний хаалганы дотор талд жижиг толь байрлуулна.
5. Хувцасны шүүгээний тасалгаа болгон тус бүр зориулалттай байна.
6. Хувцасны шүүгээний доод талын тасалгаанд гутлын хайрцаг, уут бэлтгэсэн байна.
7. Хувцасны шүүгээнд цэцэрлэгчний цүнх өлгөх дэгээтэй байна.
8. Хувцасны шүүгээнд ажилтны хувийн ариун цэврийн хэрэглэлүүд болон анхны тусламжийн хайрцаг байна.
9. Хувцасны шүүгээ нь цоожтой, ажилтны нэрийг аль нэг хэсэгт бичиж тэмдэглэсэн байна.

10.2.1.3 Усанд орох өрөө

1. Шүршүүрийн кабин бүр шалавч эсвэл хөлийн гишгүүртэй байна.
2. Шүршүүрийн кабин гарын /аваарын/ бариултай байна.
3. Шүршүүрийн кабин бүрд ариун цэврийн хэрэгслийн тавиур, дэгээ өлгүүр байна.
4. Шүршүүрийн кабин хувцас солих тасалгаатай байна.
5. Хувцас солих тасалгаа бүр сандал, хогийн сав, өлгүүр, усны шаахай байна.
6. Усны шаахайг ариутгаж, ууталсан байна.

10.2.1.4 Ариун цэврийн болон бие засах өрөө

1. Бие засах өрөө нь ялгах, таних тэмдэгтэй байна.
2. Агааржуулалтын системтэй байна.
3. Гадаа хаяг, гэрэлтүүлэгтэй байна.
4. Тааз ханын гэрэлтүүлэгтэй байна.
5. 6 хүн тутамд нэг суултуур, нэг угаалтуур, нэг шүршүүртэй байна.

6. Угаалтуурын дэргэд шингэн саван болон гар ариутгагч байна.
7. Угаалтуурын дэргэд хогийн сав байна.
8. Угаалтуурын дэргэд гар хатаагч байна.
9. Угаалтуурын дэргэд цахилгаан хэрэгслийн залгууртай байна.
10. Угаалтуурын дэргэд толь байна.
11. Угаалтуурын дэргэд дэгээ өлгүүр байна.
12. Ариун цэврийн өрөө бүрд ариун цэврийн цаас, цаас тогтоогч, хогийн сав, дэгээ өлгүүр байршуулна.
13. Ариун цэврийн өрөөний хэмжээ нь 0.9 м- ээс багагүй өргөнтэй, 1.2 м- ээс багагүй урттай, 1.08 м² –аас багагүй талбайтай байна.

10.3 Хоолны газар

1. Хоолны газар нь зориулалтын барилга байгууламжтай хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх бөгөөд дараах стандартуудын нөхцөлийг хангасан байна;
2. Энэ стандартад эш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас эш татаж хэрэглэнэ;
3. MNS CAC RCP 1:2003 - Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж);
4. MNS 4943:2015, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага;
5. MNS 4244:94, Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага;
6. MNS 5078:2001, Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага;
7. MNS 4969:2000, Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм;

11. ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ЦАГ АГААРЫН ТОХИРОМЖГҮЙ НӨХЦӨЛ

11.1 ЦЭЦЭРЛЭГЧНИЙ ҮҮРЭГ

- Цэцэрлэгч нь цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг бий болгох, төлөвлөх, арчлах, удирдах үүрэгтэй. Үүнд: мод, бут сөөгийг тарьж, ургуулах, хэлбэржүүлэх тайрах, өвс, зүлэгт талбайг хадах, хөл ургамал устгах, цэцэг тарих, усжуулалтын системийг зохицуулах, засвар үйлчилгээ хийх зэрэг бусад олон ажил багтана;
- Цэцэрлэгчдийн ажил бол ургамлыг ургалтын хувь сайн байлгахын тулд шаардлагатай улирлын чанартай арчилгаагаар хангах явдал юм. Иймд цэцэрлэгчид ургамлыг үржүүлэх, арчлах, тариалах техник технологийн талаар мэдлэг шаарддаг; Мөн шаардлагатай бол техник тоног, төхөөрөмж

ашиглах, химийн бодис эсвэл байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг ашиглан хортон шавж, мэрэгчидтэй тэмцэх, зохих хяналт тавьж зохих арга хэрэглэх;

- Цэцэрлэгжүүлэгчид нь байгалийн чулуу, мод, бетон зэрэг материалыг ашиглан цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, байгууламжийг төлөвлөх, барих үүрэгтэй;

11.2 ЦЭЦЭРЛЭГЧНИЙ АЖИЛЛАХ ОРЧИН, МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГ

- Цэцэрлэгч нар ихэвчлэн гадаа эсвэл хүлэмжид ажилладаг. Тэдний ажлын үндсэн хэрэгсэлд хүрз, зээтүү, олон үйлдлийн секатор, өвс хадагч, хэлбэржүүлэгч хөрөө, усалгааны шүршигч, тармуур, шүршигч аппарат, оройн секатор, хөрс сийрүүлэгч, хамгаалалтын бүр гэх мэт тоног төхөөрөмж багтдаг;
- Цэцэрлэгчид өөрсдийн аюулгүй байдлыг хангах үүднээс зохих хувийн хамгаалах хэрэгслийг (PPE) үргэлж өмсөж байх ёстой;
- Ерөнхийдөө ахлагчийн тушаалыг гүйцэтгэдэг ерөнхий засвар үйлчилгээний ажилчдаас ялгаатай нь цэцэрлэгчид бол хараа хяналтгүй ажиллах чадвартай мэргэшсэн ажилчид юм;
- Цэцэрлэгчдэд нээлттэй олон төрлийн ажлын боломжууд байдаг. Ихэнх нь хувиараа бизнес эрхэлдэг бөгөөд компани, зочид буудал, орон сууцны хороолол болон бусад хувийн болон нийтийн үйлчлүүлэгчид гэх мэт шууд үйлчлүүлэгчдэд цэцэрлэгжүүлэлт, талбайг арчлах үйлчилгээ үзүүлдэг;
- Бусад боломжууд нь нийтийн цэцэрлэг, цэцэрлэгийг арчлах, арчлах чиглэлээр мэргэшсэн компаниудад, арилжааны, хотын болон хувийн хэвшлийн тохижилтын бизнес эрхлэгчид, үржүүлгийн газар, цэцэрлэгийн төвүүдэд ажилладаг.
- Ажил эрхэлж буй цэцэрлэгчид амралтын өдрүүдэд ч гэсэн ээлжээр ажиллахыг шаардаж болно;
- Хангалттай туршлага хуримтлуулсан цэцэрлэгчийг манлайллын үүрэгт дэвшүүлж болно. Жишээлбэл, талбайг арчлах ажлыг гүйцэтгэдэг багийг удирдах эсвэл цэцэрлэгжүүлэлт, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг зохицуулах, хяналт тавих;

11.3 ЦЭЦЭРЛЭГЧИЙН АЖЛЫН ЦАГ АГААРЫН ТОХИРОМЖГҮЙ НӨХЦӨЛ

Хүснэгт 11.1 Хаврын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл	Нэмэлтээр авах арга хэмжээ
3	1. Үр тарих 2. Цэцэрлэгт цэвэрлэгээний огтлолт хийх 3. Өвчин, хортон шавжаас урьдчилан сэргийлэх 4. Эрт тарьсан ургамал арчлах 5. Залгагдах болон тарих мөчир бэлтгэх 6. Хүлэмжийн бэлтгэх ажил эхлэх 7. Талбайн цэвэрлэгээ хийх Мод, сөөг цаслах Мэрэгчдийг хянаж эхлэх	Ургамал ургахад цаг уурын тохиромжгүй буюу +4оС- аас бага дулаантай байна	1. Тогтмол дулаантай хүлэмж, тасалгааг ашиглан эрт тарьсан ургамлыг арчилна. 2. Цэцэрлэгчин өвлийн дулаан хувцас өмсөж ажиллана. 3. Хүйтний нөхцөлд ажиллах 4. Аюулгүй зааварчилгааг мөрдөж ажиллана.
4	1. Хөрс боловсруулах 2. Үрийг соёолуулах 3. Хөл ургамал хянаж эхлэх 4. Хортон шавж, өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх 5. Мод, сөөгийн суулгац тарьж эхлэх 6. Мод, бутыг тайрах 7. Ногоон байгууламжийн усалгаа эхэлнэ.	Хуурай салхитай, шороон шуургатай, хуурайшилт их үүснэ.	Хамгийн их ачаалалтай сар тул ажлыг дэс дараалалтай гүйцэтгэх хэрэгтэй. Цэцэрлэгчин нүдний шил, хамгаалалтын малгай, бээлий, дулаан хувцастай ажиллана
5	1. Мод, сөөгийн суулгац, үр, мөчир тарих 2. Мод үржүүлгийн ажлууд хийгдэж дуусгах 3. Мод, сөөгийг ухаж бэлтгэх Талбай цэвэрлэх, тарилтын талбай бэлтгэх 4. Зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэх, цэцгийн мандал бэлтгэх 5. Ургамал бордох 6. Ногоон байгууламжийн усалгааны ажлыг жигдрүүлэн бусад арчилгааны ажлууд хийгдэнэ.	Хуурай салхитай, шороон шуургатай, хуурайшилт их үүснэ.	Энэ хугацаанд галын аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж, цэцэрлэгчин хөдөлмөр хамгааллын хувцастай ажиллана.

Хүснэгт 11.2 Зуны улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл	Нэмэлтээр авах арга хэмжээ
6	1. Цэцгийн мандал байгуулах 2. Ногоон байгууламжийн арчилгааны ажлуудыг жигдрүүлэх 3. Зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэх 4. Мод, сөөг хэлбэржүүлэх Хөл ургамалтай тэмцэх Ургамлын өвчин хортонтой тэмцэх	Халууны улирал эхлэх тул нарших болон харшлын эх үүсвэрүүд нөлөөлж эхэлнэ.	1. Халуунаас хамгаалах малгай болон улиралд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас өмсөж ажил гүйцэтгэнэ. Мөн цув, усны гутал шаардлагатай нөхцөлд өмсөнө. Энэ үед цэцэрлэгчийн ажлын цагийн хуваарийг өөрчилж өглөө, оройн сэрүүнд ажиллуулж болно 2. Хэт халуун болон, үер усны аюулаас хамгаалах аюулгүйн ажиллагааны заавар авч ажиллана.
7	1. Ногоон байгууламжийн 2. арчилгааны ажлуудыг гүйцэтгэх Зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэх 3. Зүлэгт талбайг хадах Хөл ургамалтай тэмцэх Ургамлын өвчин хортонтой тэмцэх 4. Ногоон мөчир бэлтгэх, тарих, арчлах	Хөрсөн дээрх хүчтэй халалт, аадар бороо орох, үер усны аюул үүсэж болзошгүй цаг хугацаа.	1. Халуунаас хамгаалах малгай болон улиралд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас мөн цув усны гутлыг чийг ихтэй үед өмсөж ажил гүйцэтгэнэ. 2. Хэт халуун болон, үер усны аюулаас хамгаалах аюулгүйн ажиллагааны заавар авч ажиллана. 3. цэцэрлэгчийн ажлын цагийн хуваарийг өөрчилж өглөө, оройн сэрүүнд ажиллуулж болно 4. Хүчтэй аадар бороотой үед цэцэрлэгчийн ажлыг зогсооно.
8	1. Мод, сөөгийн үр түүж бэлтгэнэ 2. Ногоон байгууламжийн арчилгааны ажил үргэлжилнэ Хөл ургамалтай тэмцэх, зүлэгжүүлсэн талбайг хадах Өвчин хортонтой тэмцэх	Цаг агаар өглөө орой сэрүүн болж борооны улирал үргэлжилдэг	1. Цэцэрлэгчин ус цахилгааны аюулаас болгоомжлох ажлын заавар авч ажиллана. 2. Хөдөлмөр хамгааллын зуны хувцас болон чийгтэй орчинд ажиллаж багаа үед цус, усны гутлыг нэмж цэцэрлэгчинд өмсгөнө. 3. Хүчтэй аадар бороотой үед цэцэрлэгчийн ажлыг зогсооно.

Хүснэгт 11.3 Намрын улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл	Нэмэлтээр авах арга хэмжээ
9	1. Ногоон байгууламжийн талбайг самнаж цэвэрлэх 2. Мод, сөөгийг тарилтад бэлтгэх 3. Хөрс , бордоо бэлтгэх 4. Ургамал бордох 5. Ургамал шилжүүлэн суулгах Мод, сөөгийн үр түүж бэлтгэх, цэвэрлэх	Цаг уурын сэрүүний нөхцөл бий болно	1. Улирлын ажилд тохирсон хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөнө. 2. Гал, түймрээс хамгаалах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана. 3. Үндсэн ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгнө.
10	1. Мод, сөөгийг үр, суулгацаар 2. тарих, шилжүүлэн суулгах, бордох 3. Хөрс бэлтгэх, нөөцлөх 4. Мод сөөгийн усалгааг хийх Модны тогоонд хүлэрт хөрсөөр хучлага хийж өгнө. Өвлийн бэлтгэл ажлууд хийгдэнэ	Цаг агаар хүйтэрч, салхины эрч ширүүсэх үе	1. Цэцэрлэгчин улиралд тохирсон дулаан хөдөлмөр хамгааллын хувцас өмсөнө. 2. Осгох, хөлдөлтийн үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллана
11	1. Талбайг цэвэрлэнэ 2. Мод, сөөгөнд цасаар маналт хийж өгнө. 3. Мод, сөөгийг дулаална Мэрэгчдийг анхаарах үе Мод, сөөгийг дулаална	Цаг агаар хүйтэрч, цас орж хүйтний эрч чангарна.	1. Цэцэрлэгчин улиралд 2. тохирсон дулаан хөдөлмөр хамгааллын хувцас өмсөнө. 3. Осгох, хөлдөлтийн үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллана 4. Ажлын гүйцэтгэлийн явцад дулаацах, халуун, бүлээн шингэн уулгаж байх.

Хүснэгт 12.4 Өвлийн улирал дахь цэцэрлэгчийн ажлын цаг агаарын тохиромжгүй нөхцөл

Сар	Хийгдэх ажил	Цаг агаарын тохиромжгүй нөхцөл	Нэмэлтээр авах арга хэмжээ
12, 1, 2	1. Зам талбайн цэвэрлэгээ 2. Мод, сөөгөнд цас хуримтлуулах Үр тарилтад бэлтгэх	Хүйтний эрч чангарч, цас орж их хэмжээгээр орно.	1. Цэцэрлэгчин улиралд тохирсон дулаан хөдөлмөр хамгааллын хувцас өмсөнө. 2. Осгох, хөлдөлтийн үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллана 3. Ажлын гүйцэтгэлийн явцад дулаацах, халуун, бүлээн шингэн уулгаж байх.

12. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГ



Унах аюултай



Ургамал тастас болохгүй



Авир ч болохгүй



Зүлэг дээр гишгэж болохгүй



Ил гал гарах аюултай



Амны хаалт зүүх



Будагтай



Мод тарьж байна



Өхгөстэй гар хүрж болохгүй



Усалгаа хийгдэж байна



Хашаа давж болохгүй

13. ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагын цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шалгуур үзүүлэлт (хүснэгт 5.1) -ийн шаардлагыг хангаж буйг хянаж шалгана.

Хүснэгт 13.1 Цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Байгууллагын удирдлага, ХАБЭА-н мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эсэх	☐	☐
2	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журам батлуулсан, мөрдөж ажилладаг эсэх	☐	☐
3	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад техникч, цэцэрлэгчин, ажилтан нарыг хамруулсан эсэх	☐	☐
4	Хөдөлмөр хамгааллын хувцсанд тавигдах ерөнхий шаардлагыг биелүүлсэн эсэх	☐	☐
5	Хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглалтын хугацааг тогтоож мөрдөх эсэх	☐	☐
6	Анхны тусламжийн иж бүрдэлтэй хайрцаг ашиглаж байгаа Эсэх	☐	☐
7	Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн, анхны тусламжуудын мэдээлэл танилцуулах самбар байгаа эсэх	☐	☐
8	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэгчийн ажлын байранд тавигдах ахуйн шаардлага бүрэн хангагдсан эсэх	☐	☐
9	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэгчид ажил тус бүр дээр аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн өгч, бүртгэл хөтөлдөг эсэх	☐	☐

Тайлбар: Цэцэрлэгчийн хөдөлмөр, аюулгүй ажиллагааны бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** шаардлага хангаагүй бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монголын улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль.
2. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн үлгэрчилсэн жагсаалт батлах тухай.
1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал.
2. MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага.
3. MNS 5622-2006 Гарын хамгаалалт (бээлий).
4. MNS 5623-2006 Хөлийн хамгаалалт ажлын тусгай гутал.
5. MNS 5621-2006 Толгой хамгаалах хэрэгсэл дуулга.
6. MNS 4931-2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага.
7. MNS 13688-2000 Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага.
8. MNS 3306-91 Сонсголын эрхтнийг хамгаалах нэг бүрийн хэрэгсэл.
9. MNS 5388-2004 Толгой хамгаалах хэрэгсэл сонсгол хамгаалах хэрэгсэл.
10. MNS 5389-2004 Нүд хамгаалах хэрэгсэл нүдний шил чихэвч, бөглөө зэрэг хэрэгцээт стандартууд.
11. MNS ISO 1835 -3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м²-ийн жин тодорхойлох арга.
12. MNS ISO 1835 -4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга.
13. MNS ISO 1835 -5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга.
14. MNS ISO 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац суналт.
15. MNS ISO 1835-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тодорхойлох арга.
16. MNS ISO 1835 -9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга.
17. MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага.
18. MNS ISO 4010:97 Цэвэр ба хагас ноосон ээрмэл даавуу. Ноосны агуулгыг тодорхойлох арга.
19. MNS ISO 4072: 1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг угаалгад тодорхойлох арга.
20. MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
21. MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хуурай нойтон байдал үрэлтэд тодорхойлох арга.
22. MNS 4010-2009 Ширхэгтийн бүрэлдэхүүн.
23. ISO 105 Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворжилтын сорилт.

- 24. ISO 317:1995 Машинаар хуурайгаар нь цэвэрлэх үед хэмжээний өөрчлөлтийг тогтоох.
- 25. ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ-хэмжээг тодорхойлох ба авах.
- 26. ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн –хэрэглэгчдэд зориулсан тэмдгийг шошгод кодлох..
- 27. ISO 9237 Агаар нэвтрүүлэлт, агаарын эзлэхүүн, агаарын хэмжээ.
- 28. ISO 12947-2 Элэгдэл тэсвэрлэлт.
- 29. ISO 105 Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворжилтын сорилт.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж-7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



70118060



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар